

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ ТАВДУГААР САРЫН МЭДЭЭ

Нэг. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдын Хурал түүний ажлын хэсэг:

Дорноговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Байгаль орчны газраас хамтран Сайншанд сумын иргэд, хөдөлмөрчдөд “Ногоон байгууламжийн технологи”-ийн сургалтыг аймгийн “Соёмбо” цогцолборын “Иргэний танхимд” амжилттай зохион байгууллаа. Сургалтын нээлтийн үйл ажиллагаанд аймгийн ИТХ-ын дарга С.Түмэнбаяр, Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга Д.Сүрэн нар тус тус оролцсон юм.

Ногоон байгууламжийн технологийн сургалтыг аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын мэргэжилтэн С.Энхзориг зааж, хүрэлцэн ирсэн иргэдийн асуултад хариулт өгч ажиллалаа.

Хүрэлцэн ирсэн иргэдийн дийлэнх нь байгууллага болон өөрсдийн хашаандаа мод, цэцэг тарьдаг, тарих сонирхолтой иргэд байсан төдийгүй цаашид энэхүү сургалтыг үргэлжлүүлэн авах хүсэлтэй байгаагаар тус сургалтын үеэр хэллээ.

Дорноговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн ээлжит 10 дугаар хуралдаанаар “Айл өрх, иргэд, албан байгууллага бүр мод тарьцгаая” нэртэй уриалга гаргаж тус уриалгын хүрээнд иргэд, хөдөлмөрчдөд “Ногоон байгууламжийн технологи”-ийн сургалтыг аймгийн ИТХ болон Байгаль орчны газраас хамтран амжилттай зохион байгуулсан билээ. Монголчууд нэг мод таривал энэ насны буян, хоёр мод таривал хойд насны буян хэмээн ярьдаг бөгөөд хүн болж төрөөд заавал хийх ёстой үйлийн нэгд мод тарих ажил зүй ёсоор ордог. Сайншанд сумын Иргэдийн Цэцэрлэгт хүрээлэнд өнөөдөр буюу 05 дугаар сарын 04-ний өдөр 3 төрлийн 7000 гаруй модыг хөрсөнд суулгах үйл ажиллагаа зохион байгуулагдав.

Сайншанд сумын 4, 7 дугаар багуудаас сонгогдон гарсан С.Түмэнбаяраар ахлуулсан аймаг, сумын төлөөлөгчид тойрогтоо баригдаж буй бүтээн байгуулалтын ажлуудын үйл явцтай танилцаж, хяналт шалгалт хийлээ.

2019 онд Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 4, 7 дугаар багуудад эмнэлэг, 320 хүүхдийн сургууль, Найрамдал цэцэрлэгт хүрээлэн, хүүхдийн тоглоомын талбай зэрэг бүтээн байгуулалтуудын хөрөнгийг баталсан нь Төмөр замын ажилчид болон, 4, 7 дугаар багийн оршин суугчдын эрүүл, аюулгүй орчинд амьдрах, хүртээмжтэй сурч боловсрох гэх мэт олон эрхээ эдлэх боломжийг сайжруулан ажиллаж байна.

Дорноговь аймгийн ИТХ-ын 4 дүгээр багаас сонгогдон гарсан төлөөлөгч Ж.Болор-Эрдэнэ, Д.Тулга нар тойрогтоо ажиллах зардлаараа аймгийн ИТХ, Сайншанд сумын ЗДТГ, “Чандмань илч” ХХК-тай хамтран 4 дүгээр багийн “Өндөр дов” хэсэгт ухаалаг худгийг 05 дугаар сарын 09-ний өдөр ашиглалтад орууллаа.

Худгийн нээлтийн арга хэмжээнд аймгийн ИТХ-ын дарга С.Түмэнбаяр, төлөөлөгч Ж.Болор-Эрдэнэ, Д.Тулга, С.Алтанбаатар, сайншанд сумын ИТХ-ын дарга Д.Эрдэнэбаяр, Засаг дарга С.Одбаяр нар оролцон иргэдэд мэдээлэл өгч, тэдний санал хүсэлтийг хүлээн авч ажиллалаа. Уг худаг ашиглалтад орсноор иргэд 24 цагийн турш ус авах боломж бүрдэж байгаа юм.

Мөн энэхүү арга хэмжээний үеэр Сайншанд сумын ЗДТГ-аас "Иргэдэд ойр-Төрийн үйлчилгээ" аяныг Өндөр довын хэсэгт зохион байгууллаа.

Аяны арга хэмжээнд аймгийн ЭМНДХэлтэс, ХХҮГазар, УБХэлтэс, ШТГазар, ГХБХБГазрын мэргэжилтнүүд иргэдэд үйлчилгээ үзүүлэв.

Аймгийн нийт иргэдийн дунд бүх нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх, тэдний бие бялдрыг чийрэгжүүлэх, хөдөлгөөний хомстлоос урьдчилан сэргийлэх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, монгол улсад шинээр хөгжиж байгаа спортын шинэ төрөл софт волейболын спортыг сурталчлах зорилготой аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нэрэмжит Софт волейболын аймгийн аварга шалгаруулах шилжин явах цомын анхдугаар тэмцээнийг аймгийн Спортын ордонд амжилттай зохион байгууллаа. Тус тэмцээнд 37-49 насны эрэгтэй, эмэгтэй, 50-59 насны эрэгтэй, эмэгтэй, 60-аас дээш насны эрэгтэй, эмэгтэй нийт 100 гаруй тамирчид 11 сумаас ирж оролцлоо.

Тэмцээний нээлтийн үйл ажиллагаанд аймгийн ИТХ-ын дарга С.Түмэнбаяр, аймгийн ИТХ-ын тэргүүлэгч, төлөөлөгч Т.Азбаяр нар оролцон үг хэлж, тамирчдад амжилт хүслээ.

Нээлтийн үйл ажиллагааны үеэр бусдыгаа манлайлан тэргүүлэгч, спортлог ахмадуудыг шагнаж урамшуулав.

Дорноговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ээлжит 06 дугаар хуралдаан болж өндөрлөлөө. Тус Хуралаар дараах асуудлуудыг хэлэлцлээ.

1. Нэрэмжит болгох тухай
2. Монгол Улсын Төрийн дээд шагналд уламжлах тухай
3. Хөрөнгө зарцуулах тухай

Төвийн бүсийн аймгууд болох Дорноговь, Говьсүмбэр, Дархан-Уул, Дундговь, Өмнөговь, Төв, Сэлэнгэ аймгуудын ИТХ-ын ажлын албаны албан хаагчдын туршлага солилцох уулзалт, зөвлөгөөнийг 05 дугаар сарын 22-26-ны өдрүүдэд Дорноговь аймагт зохион байгууллаа. Анх 2013 онд Дорноговь аймаг зохион байгуулснаас хойш 7 дахь удаагийн зөвлөгөөнийг дахин зохион байгуулж байгаагаараа онцлог байлаа. Зөвлөгөөнд ЗГХЭГ-ын ахлах референт П.Энхсайхан, “Төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн менежер Г.Золжаргал, Монголын Нутгийн удирдлагын холбооны ажлын албаны дарга П.Янжинлхам зэрэг хүндтэй зочдоос гадна Дорноговь аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин, аймгийн ИТХ-ын төлөөлөгч С.Одбаяр, Н.Бүрэнбат, Б.Зоригтбаатар, Б.Хүдэрболд нар аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн төлөөлөл болон оролцож байна. Зөвлөгөөнд 7 аймгийн ИТХ-ын ажлын албаны 70 орчим албан хаагчид оролцсон бөгөөд харилцан суралцах аргыг хэрэгжүүлэн, бие биенээсээ суралцах, харилцан туршлага солилцоход энэхүү зөвлөгөөний гол зорилго оршиж байгаа юм.

Аймгийн итх-ын даргын өргөмжлөл

05 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар Аймгийн ИТХ-ын даргын” Хүндэт өргөмжлөл”-өөр нийт 1 иргэн, “Өргөмжлөл”-өөр нийт 25 иргэн шагнагдаад байна.

Аймгийн итх-ын даргын захирамж

05 дугаар сард нийт аймгийн ИТХ-ын даргын 15 захирамж гарсанаас ангилахад Шагнах тухай-5, Дэмжлэг үзүүлэх-8, Буцалтгүй тусламж үзүүлэх тухай-1, Хүндэтгэл үзүүлэх тухай-1 тус тус болно.

Аймгийн итх-д ирүүлсэн, явуулсан албан бичиг, өргөдлийн тухайд

Аймгийн ИТХ-ын ажлын албанд нийт 49 албан бичиг ирж, ажлын албанаас нийт албан бичиг гадагшаа 24 байгууллагуудруу явсан болно. Иргэдээс аймгийн ИТХ-д нийт 2 өргөдөл ирүүлснээс хуулийн хугацаанд 1 өргөдлийг бүрэн шийдвэрлэн ажилласан болно. Үлдсэн нэг өргөдөл дээр ажлын хэсэг байгуулж газар дээр нь хяналт, шалгалт хийхээр бэлтгэл ажил хангагдаад байна.

Хоёр. Аймгийн Засаг даргын Тамгын газар

Төрийн албаны зөвлөлөөс 2019 оны 05 дугаар сарын 17-ны өдөр аймгууд дахь Төрийн албаны салбар зөвлөлүүдтэй онлайн хурал зохион байгуулж шинэчлэн батлагдсан хуулийг нэг мөр ойлгон хэрэгжүүлэх талаар арга зүйн зөвлөмж өглөө.

Төрийн захиргааны албан тушаалын тодорхойлолтыг хянах ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж байна.

Төрийн албаны салбар зөвлөлд хандан гаргасан 1 өргөдлийн дагуу Даланжаргалан суманд ажиллаж төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангуулах, үйл ажиллагааны үр дүнг үзэж шалгалт зохион байгуулан дүгнэлтийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн.

Аймгийн эдийн засаг нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсаны дагуу 2019 оны 06 дугаар сарын 13-15-ны өдрүүдэд багийн Засаг дарга нарын Нэгдсэн сургалтыг Эрдэнэ сумын Бүрдэнэ багт зохион байгуулахаар төлөвлөн, бэлтгэл зохион байгуулалтын ажил хийгдэж байна. Энэхүү сургалтад 14 сумын 64 багийн Засаг дарга нар оролцож, цэргийн болон гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлийн сургалтдад хамрагдаж мэдлэг, ур чадвараа дээшлүүлэн, харилцан туршлага судална.

Сургалтад аймгийн Цэргийн штаб, Онцгой байдлын газар, Статистикийн хэлтэс, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Тогтвортой амжиргаа-3 төслийн баг, Боловсрол сэтгэл судлалын академи оролцоно.

2019 оны 05 дугаар сарын 06-ны өдрөөс 14 хоногийн хугацаатай 12 багийн 28 багийн Засаг дарга нар өөр сумдад туршлага судлах, мэдлэг ур чадвараа дээшлүүлэх зорилгоор сэлгэн ажиллаж, ажилласан хугацаандаа тухайн сумын сэлгэн ажилласан багт өөрийн санаачлагаар зохион байгуулсан үйл ажиллагаа, бүтээлч ажил, сэлгэн ажиллахын ач холбогдлын талаар зурган тайлан хийж, ажлаа дүгнүүлсэн.

Аймгийн Эмэгтэйчүүдийн зөвлөл, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хотын Эмэгтэйчүүдийн хорооны хамтын ажиллагааны хүрээнд 2019 оны 5-р сарын 11-ны өдөр Дорноговь аймгийн Засаг даргын орлогч Г.Эрдэнэцэцэгтэй уулзлаа. Уулзалтаар хоёр орны Эмэгтэйчүүдийн соёл урлаг, гоо зүйн боловсрол, хөдөлмөр эрхлэлт, аялал жуулчлал зэрэг бусад чиглэлээр туршлага солилцох, хамтын ажиллагааг өргөжүүлэх тухай ярилцлаа. Энэхүү уулзалтад Аймгийн эмэгтэйчүүдийн анхан шатны зөвлөл, БНХАУ-н ӨМӨЗО-ны Эрээн хотын Эмэгтэйчүүдийн хорооны төлөөлөгчид оролцлоо.

Монгол-Хятад 2 улс дипломат харилцаа тогтоосны 70 жилийн түүхэн ойг тохиолдуулан БНХАУ-ын Замын-Үүдэд суугаа Ерөнхий консулын газартай хамтран ЕБС-ийн 6-аас дээш ангийн 90 сурагч 10 багшийг БНХАУ-ын Эрээн хотод 2019 оны 5-р сарын 28-ны өдөр нэг өдрийн аялал хийлгэв. Аялалаар сурагчид Үлэг гүрвэлийн музейтэй

танилцах, Хүүхдүүд Эрээний Хүүхдүүдтэй хамт урлагийн номер гаргах, Кино үзэх зэрэг үйл ажиллагаанд оролцов.

Нийгмийн бодлогын хэлтэс:

Нийгмийн даатгалын хэлтэс:

Нийгмийн даатгалын сангийн орлого зарлага

Нийгмийн даатгалын хэлтэс 2019 онд нийгмийн даатгалын санд 29949216,3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж 16578 иргэнд 41934483,0 мянган төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг хугацаанд нь олгохоор ажиллаж байна.

НЭГ. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА

2019 оны 04 дугаар сарын мэдээгээр нийгмийн даатгалын санд 8971293.7 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 11490868.7 мянган төгрөгийг төвлөрүүлж, сангийн орлого 128.08 хувийн биелэлттэй байна. Нийгмийн даатгалын сангаас 11065 иргэнд 13673133.06 мянган төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг хугацаанд нь олгож ажиллалаа.

Үүнийг сан тус бүрээр харуулбал:

Орлого /Мян.төг/

Нийгмийн даатгалын сан	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Тэтгэврийн даатгалын сан	7291587.8	8681593.60	119.06
Тэтгэмжийн даатгалын сан	756808.3	983426.80	129.94
ҮОМШӨ-ний даатгалын сан	765384.1	1432104.70	187.11
Ажилгүйдлийн даатгалын сан	157513.5	393743.60	249.97
Дүн	8971293.70	11490868.70	128.08

Зардал /Мян.төг/

Нийгмийн даатгалын сан	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
		Мөнгөн дүн	Хувь	Хүний тоо
Тэтгэврийн даатгалын сан	12257014.20	12130439.20	98.97	8348
Тэтгэмжийн даатгалын сан	933705.30	920048.56	98.54	2363
ҮОМШӨ-ний даатгалын сан	289965.50	294329.70	101.51	170
Ажилгүйдлийн даатгалын сан	331743.80	328315.60	98.97	184
Дүн	13812428.80	13673133.06	98.99	11065

1.1 Тэтгэврийн даатгалын сангаас бүх төрлийн тэтгэвэрт нийт 8348 хүнд 12125802.3 мянган төгрөгийн тэтгэвэр олгосон. Үүнд:
Мян.төг

Тэтгэврийн даатгалын сан	Тэтгэвэр авагчийн тоо	Олгосон тэтгэвэр
Өндөр насны тэтгэвэрт	6135	9020655.7
Тахир дутуугийн тэтгэвэрт	1274	1417291.2
Тэжээгчээ алдсаны тэтгэвэрт	501	590995.6
Цэргийн тэтгэвэр	438	1096859.8
Дүн	8348	12125802.30

1.2 Тэтгэмжийн даатгалын сангаас нийт 2363 даатгуулагчилд 918158.4 мянган төгрөгийн тэтгэмж олгосон.

Үүнд:

Тэтгэмжийн даатгалын сан	Тэтгэмж авагчийн тоо	Олгосон тэтгэмж
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны	1828	227535.8
Жирэмсэн амаржсаны	427	582622.6
Оршуулгын	108	108000
Дүн	2363	918158.40

1.3 ҮОМШӨ-ний даатгалын сангаас 170 даатгуудагчид 294329,68 мянган төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгосон. Үүнд:

ҮОМШӨ-ны даатгалын сан	Тэтгэвэр, тэтгэмж авагчийн тоо	Зарлага
Тахир дутуугийн тэтгэвэр	122	236061.9
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	29	49123
Тэтгэмж, төлбөр	17	7724.38
Сувилалын зардал	2	1420.4
Дүн	170	294329.68

1.4 Ажилгүйдлийн даатгалын сангаас нийт 184 даатгуулагчид 326942,04 мянган төгрөгийн тэтгэмжийг олгосон байна.

ХОЁР. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН АВЛАГА

Мянган төгрөг

Сангийн авлага	2018.12.31-ны байдлаар	2019.04.30-ний байдлаар
Нийт шимтгэлийн авлага	1515846,5	1506235,0
Төсөвт байгууллага	35086,9	156922,3
ААН байгууллага	1480759,6	1349312,7

ГУРАВ. ӨМНӨХ ОНЫ ХАРЬЦУУЛАЛТ

3.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, төрлөөр, жил бүрийн 4 сард

Үзүүлэлт	2018.04	2019.04	2019 4 2018 4
	сая төгрөг		хувь
Нийгмийн даатгалын сангийн орлого	8743,9	11490,8	131,4
Тэтгэврийн даатгалын сан	6606,2	8681,6	131,4
Тэтгэмжийн даатгалын сан	747,4	983,4	131,6
Эрүүл мэндийн даатгалын сан	0	0	0

ҮОМШӨ*-ний даатгалын сан	1089,8	1432,1	131,4
Ажилгүйдлийн даатгалын сан	300,5	393,7	131,0
Нийгмийн даатгалын сангийн зарлага	12106,1	14279,5	118,0
Тэтгэврийн даатгалын сан	10432,6	12130,4	116,3
Тэтгэмжийн даатгалын сан	782,0	920,0	117,6
Эрүүл мэндийн даатгалын сан	0		0
ҮОМШӨ*-ний даатгалын сан	651,6	900,8	138,2
Ажилгүйдлийн даатгалын сан	239,9	328,3	136,8

3.2 НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИД, ОЛГОСОН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 4 сард

Үзүүлэлт	2018.04	2019.04	2019.04 2018.04
	хүн		хувь
1. Нийгмийн даатгалд даатгуулагчид	17156	17217	100,4
Албан журмаар даатгуулагчид	14586	15289	104,8
Аж ахуй нэгж, байгууллага	7296	7786	106,7
Төсөвт байгууллага	7290	7503	102,9
Сайн дураар даатгуулагчид	2570	1928	75
2. Тэтгэвэр авагчдын тоо	8047	8499	105,6
Өндөр насны тэтгэвэр	5768	6135	106,4
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн	1195	1274	106,6
Тэжээгчээ алдсаны	516	501	97,1
Цэргийн тэтгэвэр	412	438	106,3

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар:

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээ 2019 оны 05сарын байдлаар

Үйлчилгээ	Тоо хэмжээ
Шинэ ажлын байрны тоо:	92 өмнөх оны мөн үеийнтэй адил
Ажилд зуучлагдсан иргэдийн тоо:	220 өмнөх оны мөн үеийнхээс 60,4 хувиар өссөн
Ажлын байрны захиалгын тоо:	231 өмнөх оны мөн үеийнхээс 88,3 хувиар өссөн

Зохион байгуулсан нийтлэг арга хэмжээ:

1. ХИЛИЙН ЦЭРГИЙН 0184-Р АНГИД АЛБА ХААСАН ЦЭРГҮҮДЭД МЭДЭЭЛЭЛ ХИЙВ.Хилийн цэргийн 0184-р ангид цэргийн алба хааж халагдан ирж буй цэргүүдийг 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдөр хүлээн авч ажил хайгчаар бүртгэн, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээг үзүүлж, хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийг танилцуулж нийт 49 цэргийг бүртгэн мэдээлэл хүргэж ажиллаа.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяны хүрээнд зохион байгуулсан арга хэмжээ:

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяны хүрээнд ажлын байрны аюулгүй ажиллагааны хууль, дүрэм, журам, эрх зүйн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор төрийн байгууллагуудын дунд “**Дэвжээ-2019**” тэмцээнийг 2019.05.01-2019.05.02-ны өдрүүдэд Дорноговь аймгийн “Саран Хөхөө” театрт амжилттай зохион байгууллаа. Уг тэмцээн нь 2 үе шаттайгаар зохион байгуулагдсан. Эхний шатны шалгаруулалт сумдад зохион байгуулагдаж шалгарсан 1 баг нь шийдвэрлэх тэмцээнд оролцлоо. Шилдгийн шилдэг 15 баг 1.0 сая төгрөгний шагналын сантай супер тоглолтонд оролцож 1-р байр өргөмжлөл 1.0 сая төгрөгний эзнээр Сайншанд сумын 9-р цэцэрлэгийн “Саруул дэнж” баг, 2-р байранд Замын-Үүд сумын “Замын-Үүд” баг шалгарч өргөмжлөл, 800.0 мянган төгрөг, 3-р байранд Сайншанд сумын ЕБоловсролын 5-р сургууль шалгарч өргөмжлөл, 500.0 мянган төгрөгний эзнээр тодорлоо.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян болоод зорилтот жилийн хүрээнд нийгмийн хариуцлагынхаа хүрээнд “Доншен” ХХК, “МАК”, “Монцемент” ХХК-ууд ивээн тэтгэж тус бүр 3.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг үзүүлжээ.

2019 оны 05 сарын 09-ны өдөр Сайншанд сумын ЗДТГазраас хэрэгжүүлсэн “Иргэдэд ойр төрийн үйлчилгээ аян”-ы хүрээнд 1 болон 7-р багийн нийт 55 иргэнд хөдөлмөр эрхлэлт болон нийгмийн халамжийн үйлчилгээний талаарх мэдээллийг агч ажиллалаа

“Миний сонгосон мэргэжил” үйлдвэртэй танилцах мэргэжил судлах автобустай аялал: Тус газраас зохион байгуулдаг мэргэжил судлах автобустай аялал энэ жил Даланжаргалан сумын нутагт үйл ажиллагаа явуулдаг “МАК”цемент ХХК-ийн үйлдвэр дээр 5 сарын 24-ний өдөр зохион байгуулагдлаа. Аялалд 1,2,5-р сургуулийн ахлах ангийн сурагчид, МСҮТ-н гагнуурын ангийн оюутнууд оролцлоо. Уг аялалд нийт 40 сурагч, 4 багш хамрагдав.

Хүүхдүүд тус үйлдвэрт ямар ямар мэргэжлийн хүмүүс ажилладаг, тухайн мэргэжлээр ямар сургуулиуд мэргэжилтэн бэлтгэн гаргадаг, тухайн мэргэжлийн онцлог зэргийн талаар чөлөөтэй ярилцан нэг өдрийг сонирхолтой өнгөрүүлээ.

2. Төсөл хөтөлбөрийн хүрээнд:

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд:

Эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэгийн төслийг сонгон шалгаруулах ажлын хэсэг хуралдаж нийт 21 төсөл ирснээс батлагдсан квотод багтаан 8 төслийг сонгон шалгаруулж 24.0 сая төгрөгний санхүүжилтийг олголоо. Шалгарсан төслийг үйл ажиллагааны чиглэлээр нь авч үзвэл оёдол, модон эдлэл, талх нарийн боов, фото зураг, гар урлал, үсчин, дугуй засвар байна.

Ахмадын зөвлөх үйлчилгээнд 3 байгууллага / Сайншанд сумын 13-р цэцэрлэг, Мишээлт мана, Агатова өрхийн эмнэлэг/ хүсэлт ирүүлсэн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд:

Аж ахуй эрхлэлтийн сургалтыг төсөл бичих чиглэлээр зохион байгуулж 34 иргэнийг хамруулсан бөгөөд эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийн төслийг хүлээн аваад байна.

Залуучуудын гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд:

Хөтөлбөрийн аж ахуй эрхлэлтийн сургалтыг 06 сарын 11-13-ны өдөр, START-UP гарааны бизнесийг дэмжих арга хэмжээний сургалтыг 06 сарын 14-16-ны өдрүүдэд зохион байгуулахаар зар мэдээллийг нийтэд түгээгээд байна.

Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд:

Аж ахуй эрхлэлтийн сургалтыг төсөл бичих чиглэлээр Сайншанд, Замын-Үүд сумдуудад зохион байгуулж 93 иргэнийг хамруулсан бөгөөд эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт 37 төслийг хүлээн аваад байна.

Нийтийг хамарсан ажлыг 12 суманд зохион байгуулахаар шийдвэрлэж, зарим сумдын ажлууд эхлээд байна.

Бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээнд одоогоор 4 бүлэг үйл ажиллагаа эхлэх бэлтгэл ажлаа хангаад байна.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд:

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн өрхийг малжуулах арга хэмжээний хүрээнд малжих сонирхолтой 37 өрхийн материалыг хүлээн авч ажлын хэсгийн хурлаар оруулахад бэлдээд байна.

3. Нийтлэг үйлчилгээний хүрээнд:

АМЧБОЗӨ ганцаарчилсан зөвлөгөөг өссөн дүнгээр 205 иргэнд /115 эмэгтэй/, бүлгийн зөвлөгөө сургалтыг 458 иргэнд /эмэгтэй 270/ өгч ажилласан байна.

"ХӨГЖЛИЙН ТҮҮЧЭЭ" ЕБС-ийн төгсөх ангийн сурагчдад бүлгийн сургалт зохион байгууллаа. Ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагчдад мэргэжлээ зөв сонгоход нь туслах, "Сайн бүхний эхлэл-Сайншанд хот"-ын ирээдүйн хөгжлийн талаар мэдээлэл өгөх, орон нутагтаа эргэн ирж ажиллах боловсон хүчний тоог нэмэгдүүлэх зорилгоор "Хөгжлийн түүчээ" уулзалтыг 2019 оны 05 дугаар сарын 04-ний өдөр Саран хөхөө театрт зохион байгууллаа.

Улаанбаатар хотын "Бест метод" сургалтын төвийн захирал Г.Нэргүй болон лектор багш Мандухай нар хүрэлцэн ирж ЭЕШ-2019, "Ирээдүйн эхлэл-өнөөдөр" зэрэг сэдвээр илтгэл тавьж, мэдээлэл хийлээ. Сургалтанд Сайншанд сумын 1,2,3,4,5-р сургуулийн 210 сурагч анги удирдсан багш нарын хамт оролцлоо.

Ажил хайгч иргэнийг бүртгэх:

Ажил хайгчаар бүртгүүлэх хүсэлтэй нийт 230 иргэний бичиг баримтын бүрдлийг бүрдүүлэн анкетийг бөглүүлэн хүлээн авч ХЗЗ-н LMIS программд бүртгэж ажилласан мөн тухайн тайлант хугацаанд идэвхгүй төлөвт шилжсэн 300 иргэдийн бүртгэлийг тухай бүрт нь сэргээн шинэчлэн

ажилласан байна.Тайлант хугацаанд сумдын мэдээг нэгтгэн ажил хайгчаар бүртгүүлсэн иргэдийн мэдээллийг санд оруулсан.

Ажлын байрны захиалга:

Орон нутагт үйл ажиллагаа эрхлэн явуулж буй ААН,Байгууллагуудтай холбогдож сул чөлөөтэй ажлын байрны захиалгыг тухай бүрт нь авч 7 хоног бүр өөрчлөн ажилласан мөн сумдаас ирүүлсэн сарын тайлан мэдээнд сул чөлөөтэй ажлын байрны захиалгуудыг нэгтгэн гаргаж мэргэжилтэн бүрт хүргэн мөн телевиз радио болон facebook, пэйж хуудсуудаар зар мэдээг иргэдэд хүргэж ажилласан.

Нийгмийн халамжийн сангийн талаар:

05 дугаар сард Төрийн банкаар дамжин нийт 5837 иргэнд 473,6 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмж олгожээ. 2019 оны 1-4 сарын байдлаар олгосон тэтгэвэр тэтгэмж болон ирэх саруудын хүлээгдэж буй гүйцэтгэлийн судалгааг төрөл тус бүрээр гарган ХХҮЕГазарт явуулсан ба санхүүжилт дутагдалтай байх магадлалтай зардлуудад тусгай тайлбар давхар хүргүүлээ.

ӨМНсангийн талаар:

Аймгийн хэмжээнд өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгааны 45 өргөдөл хүлээн авсан ба эдгээр өрхүүдээр зочилон судалгаа авах ажил хийгдэж байна. Өмөнх саруудад судалгаа хийгдэж оноо бодогдох үед мэдээлэл зөрүүтэйн улмаас дахин баалгаажуулалт хийгдэх 32 өрхийн мэдээлэл ирсэн ба дахин холбогдож баталгаажуулж ажиллаж байна.

4-р сард Шинэ төрсөн хүүхдийн эцэг эхийн 90 өргөдлийг хүлээн авч програмд бүртгэн мэдээлэл өглөө.

ХБИ, ОНОТХҮ-ний талаар:

Монгол Улсын Ахмад настны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 11 дүгээр зүйлийн 11.2.2, 11.2.5, 13 дугаар зүйлийн 13.1, 43 дугаар зүйлийн 43.1.1, 43.1.3 дахь заалт, Монгол улсын MNS 6055:2009, MNS 6056:2009, MNS 5682:2006 стандартын хэрэгжилтийг ханган ажиллах, Аймгийн хэмжээнд 2215 хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 0-16 насны 219 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байгаа бөгөөд эдгээр иргэдийг энгийн иргэдийн адил нийгмийн харилцаанд оролцох нөхцлийг бүрдүүлж ажиллах талаар 2019 оны 05 сарын 16-нд ХХҮГазрын даргын 176 тоот чиглэлийг сумдын Засаг дарга нарт хүргүүлэв. Хийсэн ажлын тайлан гарсан үр дүнгийн тайланг 09 дүгээр сард авах юм.

Тайлант хугацаанд Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурал 5 удаа, ХБХЭМБНХСКомиссын хурал 1 удаа хуралдсан ба эдгээр иргэд, хүхдийн мэдээллийг тухай бүр шинэчилэн, мэдээллийн санг сар сараар нь шинэчилэн ажиллаж байна.

ОНОТХҮйлчилгээ үзүүлэх дээр тендер ирүүлсэн 2 аж ахуй нэгж, төрийн бус байгууллагуудын баримт бичгийг **tender.gov.mn**сайтаас гаргаж тендерийг үнэлэх жагсаалтыг бэлтгэн үнэлгээг хийв. Мөн 2019 оны 05 дугаар сарын 06-нд дутуу материал ирүүлсэн 2 төрийн бус байгууллагад хугацаатай албан тоот хүргэв. 2019 оны 05 сарын 10-нд Үнэлгээний хороог хуралдуулж хугацаатай албан тоот хүргэсэн төрий бус байгууллагын тендерийн баримт бичгийг хянан үзэж хэлэлцэв.

ОНОТХҮйлчилгээ нь дээр тендер заралсантай холбогдуулж 05 сарын 20-нд Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, дүгнэлтийг ХХҮГазрын даргад танилцуулж багц-1,2 дээр дахин үнэлгээний хороог хуралдуулах талаар зөвлөмж авч 05 сарын 24-нд ХХҮГазрын даргын Сайншанд суманд “Сэргээн засах үйлчилгээ” үзүүлдэг Эрүүл мэндийн тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын судалгааг 2019 оны 05 сарын 28-ны дотор ирүүлэх 190

дугаартай албан тоот хүргүүлэв. 2019 оны 05 сарын 29-нд тус тоотын хариу ирсэнтэй холбогдуулж үнэлгээний хороогоор дахин хэлэлцэх талаар төлөвлөн ажиллаж байна.

ХЭБ-ийн үйлчилгээний талаар:

Хүнсний эрхийн бичгийн 1, 2, 4, 6, 7, багийн иргэдэд ХНХЯамын сайдын 2018 оны А/13 дугаар тушаал, Хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээ, төсөл хөтөлбөрүүдийг танилцуулж, хувийн хэрэгт хавсаргаж, программтай тулгаж, дэлгэрэнгүй судалгаа гарган ажиллаж байна

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд шинээр хамрагдах болзол хангасан 130 өрхөд сумын амьжиргаа дэмжих зөвлөлийн гишүүдтэй хамтран нөхцөл байдлын үнэлгээ хийж болзол хангасан 58 өрхийг шинээр хамруулах талаар хүсэлтийг ХХҮЕГ-т албан бичгээр хүргүүлээ.

Сангийн мэргэжилтэн ажлаас чөлөөлөгдсөн ба Төрийн албаны тухай хуулийн дагуу нөөцөд бүртгэлтэй хүн байхгүй байгаатай холбоотой 3-р сараас эхлэн ХЭБ-ийн үйлчилгээ олгогдоогүй байна.

Сумдын хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ үзүүлэх дэлгүүр сонгон шалгаруулалтыг зарлаж, Сайншанд, Замын-Үүд, Мандах сумдаас бусад сумд гэрээ байгуулан ажиллаж байна.

Зорилтот өрхийн хөгжил хамгааллын талаар:

Зорилтот бүлгийн өрхүүдийн судалгааг гарган 5 өрхөд АЗДТГ-аас Их бүтээн байгуулалтын жилийн нээлтийн арга хэмжээний үеэр 3*4 харицаатай Солонгос хүлэмж гардуулж хүнсний ногоо тариалж өрхийн орлогоо нэмэгдүүлэх боломжоор хангалаа.

Бусад:

Монгол Улсад Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв Байгууллага байгуулагдсаны 60 жил, Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага байгуулагдсаны 100 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан “ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАРЫН НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ”-ийн арга хэмжээнд тус газрын мэргэжилтнүүд оролцож аймгийн хэмжээнд 2287 иргэнд мэдээ мэдээлийг хүргэсэн байна.

Сайншанд сумын 1-р багийн ахмадын зөвлөгөөнд оролцогч ахмадуудад нийгмийн халамжийн хууль тогтоомж, тусламж хөнгөлөлтийн талаар мэдээлэл хийлээ.

2019 оны 05 сарын 17-ны өдөр Дорноговь аймгийн тамгын газраас Их бүтээн байгуулалтын жил болгон зарласантай холбогдуулан төв талбай дээр нээлтийн арга хэмжээний өдөрлөгт оролцож иргэдэд мэдээ мэдээлэл өгч ажиллалаа.

ЭХМКомиссын гишүүд болон комиссын хурлаар орж хөдөлмөр алдалтын хувь хугацаа шинээр тогтоолгож, сунгуулж байгаа иргэдэд Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүний эрхийн тухай хуулийн талаар мэдээлэл сургалт хийлээ.

МУ-ын Ерөнхий сайдын 2019 оны 04 дүгээр сарын 17 ны өдрийн “Улсын үзлэг зохион байгуулах төв комиссын бүрэлдэхүүн, удирдамж батлах тухай” 46 дугаар захирамжийн дагуу ХХҮГазрын даргын 2019 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/21 тоот “Архивын улсын үзлэгт бэлтгэх ажлыг зохион байгуулах байгууллагын комисс” ажлын хэсгийн гишүүдээс гадна хэлтсийн хэмжээнд бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллалаа.

Тайлант сард аймгийн хэмжээнд хүчтэй шороон шуурга шуурсан ба шуурганы үеэр амьдарч байгаа гэр нь нурсан дахин ашиглагдахгүй болсон иргэдийн мэдээллийг цуглуулж байна. Мөн эдгээр иргэдийн нөхцөл байдлын үнэлгээг хийлээ.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар

Нэг. Салбарын болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилт, дүрэм, журамд санал өгсөн байдал, хэрэгжилт:

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд:

Тус сард хүүхдийн тусламжийн утсанд 4 дуудлага бүртгэгдсэнийг харьяаллын дагуу Замын-Үүд, Сайншанд сумдад шилжүүлэн хяналт тавьж ажиллаж байна. Тус дуудлагуудыг ангилж үзэхэд гэр бүлийн орчинд бие махбодын хүчирхийлэлд өртсөн 1, боловсролын орчинд бие махбодын хүчирхийлэлд өртсөн 1, үл хайхрах хүчирхийлэлд өртсөн 2 дуудлагууд тус тус байна. Дээрх 4 дуудлагад хамтарсан баг болон ГБХЗХГ-ын мэргэжилтнүүд нөхцөл байдлын үнэлгээ хийж, 2 удаагийн эрх зүйн зөвлөгөө, 2 удаагийн сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлж ажиллалаа.

Гэр бүлийн гишүүд бие биеэ хайрлах, хүндлэх, гэр бүлийн үнэ цэнийн тухай ойлголт хандлагыг нэмэгдүүлэх, Хууль ёсны гэр бүлийг дэмжих зорилго бүхий шинээр гэр бүл болж буй гэр бүлүүд, төрсний гэрчилгээ гардан авч буй хүүхдүүдэд зориулж “Гэр бүлийн гэрлэлтийн баталгаа, төрсний гэрчилгээ”г гардуулах үйл ажиллагааг зохион байгууллаа. Тус үйл ажиллагаанд Сайншанд сумын харьяат 4 хос, 2 шинээр мэндэлсэн хүүхдэд гэрчилгээг хүндэтгэлтэйгээр гардуулж өглөө. Ёслолын үйл ажиллагааны үеэр Гэр бүлийн үнэ цэнэ сэдвээр мэдээлэл хүргэж баталгаагаар гардан авсан гэр бүлүүдэд монголын гэр бүлийн тангараг дурсгалаа.

Аймгийн Засаг даргын захирамжаар 2019 оныг “Гэр бүлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан гэр бүлийн үнэт зүйлсийг бэхжүүлж, гэр бүлийн бат бэх тогтвортой байдлыг хангах, хүүхдийн эрхийг дээдэлж үр хүүхдээ үлгэр жишээ зөв төлөвшилтэй иргэн болгон төлөвшүүлж буй гэр бүлийг алдаршуулан нийгэмд эерэг нөлөө үзүүлэх зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Аймгийн "Шилдэг гэр бүл" шалгаруулах арга хэмжээг Аймгийн эмэгтэйчүүдийн зөвлөл, аймгийн Засаг даргын тамгын газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар хамтран зохион байгууллаа.

Залуу гэр бүлийн хөгжил, боловсрол, тогтвортой байдлыг дэмжих, нийгмийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, хүүхдэд ээлтэй гэр бүлийн орчныг дэмжих, гэр бүлийн гишүүдийн тэгш оролцоог хангах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор "Хүүхэд нэг эрдэнэ-хүмүүжил мянган эрдэнэ сэдэвт аймгийн залуу гэр бүлийн зөвлөгөөн"-ийг энэ оны 05-р сарын 24-ний өдөр зохион байгууллаа. Арга хэмжээний хүрээнд шинээр гэрлэлтээ бүртгүүлж буй 4 гэр бүлд гэрлэлтийн баталгаа, шинээр төрсөн 1 хүүхдэд төрсний гэрчилгээг нь ёслол хүндэтгэлтэйгээр гардуулав.

Мөн үр хүүхдээ амьдрах ухаанд сургаж, харилцааны зөв хэвшилтэй, бусдыг хүндлэх, хариуцлагатай иргэн болгон төлөвшүүлж байгаа зөвлөгөөний оролцогч 3 залуу гэр бүлийн төлөөлөл Сайншанд сумын иргэн О.Мөнхбат, Б.Одонтуяа нарын гэр бүл, Жаргалсайхан овогтой Монгол, гэргий Баянбаатар овогтой Ундрахзаяа нарын гэр бүл, Уртнасан овогтой Энхболдын Гэргий Амаржаргал овогтой Шинэчимэг нарын гэр бүлд хүндэтгэл үзүүлж алдаршууллаа.

Зөвлөгөөнд гэр бүл судлаач лектор Ж.Баясгалан оролцож гэр бүлийн үнэ цэнэ, үр хүүхдээ зөв хүмүүжүүлэн төлөвшүүлэх, хосын харилцааны талаар лекц болон сэтгэл зүйн дасгал тоглоомуудыг ажилууллаа.

Аймгийн хэмжээнд эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн судалгааг авч нэтгэн Эрсдлийн программд шивж оруулан хамгийн өндөр эрсдэлтэй 110 хүүхдийг “Хүүхэд хамгааллын даатгал”-д хамруулахаар ажиллаж байна. Энэхүү даатгалыг Номин даатгалын компанид даатгалуулахаар ажиллаж байна.

Шүүхээс албадлагын арга хэмжээ авч Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны хяналтад байгаа 7 хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчтай уулзаж хамтран ажиллах гэрээг шинээр байгуулан төлөвлөгөөний дагуу сургалт, нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулахаар ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын А/334, 355 дугаар захирамжаар баталсан Дорноговь аймгийн шигшмэл хурд”, “Ирээдүйн түмэн эх”, Айраг суманд зоион байгуулагдсан “Боржигон хурд” хаврын бүсийн хурдан морины уралдаанд уралдаанч хүүхдийн бүртгэлийг хурууны хээг уншуулан цахимаар бүртгэн, уралдааны замд гарахад нь хүүхдийн мэдээллийг тулгаж, уралдаанч хүүхдийн хувцас хэрэглэлийн стандартад хяналт тавиж, аюулгүй байдлыг нь хангаж ажиллалаа.

Хоёр. Төсөв, хөрөнгө оруулалт болон Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн хүрээнд:

Байгууллагын үйл ажиллагааны сарын мэдээ, батлагдсан төсөв, тушаал шийдвэр, мэдээллийг Шилэн дансны сайтад сар бүрийн 8-ны дотор байршуулан шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Гурав. Төрийн захиргааны байгууллагын манлайллыг бэхжүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах ажлын хүрээнд:

Засгийн газраас хэрэгжүүлж буй “Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь” төслийн хүрээнд НҮБ-ын хүн амын сан, ШХА-ийн техник, санхүүгийн дэмжлэгтэй хийгдсэн, “Хүчирхийллийн нүцгэн үнэн” судалгааны үндсэн үр дүнг танилцуулах семинар, хэлэлцүүлэгт байгууллагын 2 албан хаагч хамрагдлаа.

Дөрөв. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил, хамгааллын асуудлаар түншлэгч талууд /олон улсын, иргэний нийгэм болон ТББ/-тай хамтран ажиллах хамтын ажиллагааг

“Монголын хүүхдүүд” хүүхдийн урлагийн их наадмын говийн бүсийн 2 дугаар шатны шалгаруулалтад аймгаа төлөөлөн 60 хүүхэд 6 багшын бүрэлдхүүнтэй оролцож 3 хамтлаг бүжиг, ардын хамтлаг дуу, гоцлол дууны төрөлд тус тус 24 хүүхэд 3 дугаар шатны шалгаруулалтад оролцох батламж гардан авлаа.

Аймгийн хүүхдийн нэгдсэн зөвлөл, хүүхдийн оролцооны байгууллагаг цагын хуваарийн дагуу цуглаж арга зүйн зөвлөгөө авч ажиллаж байна. Үүнд: Гайхамшигт бямба гариг гэр бүлийн өдөр, “Зөв тусгал-Гэрэлт ирээдүй” арга хэмжээнд нэгдэн үзэл бодлоо илэрхийлж дуу хоолойгоо сонсголоо.

Ирээдүйн эзэд мэргэжил сонголтын аяныг ерөнхий боловсролын сургуулийн 9-р ангийн сурагчдад мэргэжил сурталчлах экспод 904 өсвөр үе, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвтэй танилцах аялалд 377 сурагчийг хамруулан зохион байгуулав. Уг арга хэмжээг зохион байгуулснаар мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн элсэлт авч буй ангиуд, сургалтын орчин, дадлагын байр, ажиллах нөхцөл зэргийг 9-р анги төгсөгч сурагчид судалж, Мэргэжил сонголтын лекцийг нийт 2875 сурагчид хүргэн ажиллав.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хорихоос бусад ял эдэлж буй 4-н хүмүүжигч нарын АУС-ийг дуусгаж, гэр бүлийн өдрөөр сертификатыг гардуулан гэр бүлийн гишүүдийн хамт 8 иргэнд АУС-ийг “Харилцаа” сэдвээр зохион байгууллаа.

Тав. Байгууллагын үйл ажиллагааг хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээгээр сурталчилсан ажлын хүрээнд:

Гэр бүлийг дэмжих жилийн хүрээнд Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичгийн хэрэгжилт, 2019 онд хийгдэх ажлын чиглэлийн талаар орон нутгийн телевизүүдэд ярилцлага өгч, нийт 14 хүүхдийн эрх, хамгааллын талаарх шторкийг орон нутгийн ДТВ-ээр цацуулан ажиллаж байна.

Зургаа. Бусад ажлын хүрээнд:

Хотын иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх нийтийн цэвэрлэгээний хүрээнд хуваарьт талбайн цэвэрлэгээнд оролцлоо.

Бүх нийтээр мод тарих үндэсний өдрөөр байгууллагын албан хаагчид бүрэн хамрагдаж байгууллагынхаа өмнө 5 мод тарилаа.

Сайншанд сумын “Иргэнд үйр-Төрийн үйлчилгээ” 7 багийн нээлттэй хаалганы өдөрт оролцож хүүхдийн эрх, хамгаалал, уралдаанч хүүхдийн нрхийн талаарх нийт 500 гаруй иргэдэд гарын авлага тараалаа.

Биеийн тамир, спортын газар:

Аймгийн Засаг даргын 2019 оны А/378 дугаар захирамжаар “Дорноговь Бага олимп-2019” спортын наадмыг 2019 оны 05 дугаар сарын 22-25-ны өдрийн хооронд 14 сум, Сайншанд сумын 7 багийн нийт 800 гаруй иргэдийг хамруулан зохион байгуулсан. Бага олимпийн наадмын багийн нийлбэр дүнгээр 1 дүгээр байранд: Замын-Үүд сумын баг, тамирчид, 2 дугаар байранд: Сайншанд сумын 3-р багийн тамирчид, 3 дугаар байранд: Сайхандулаан сумын баг, тамирчид тус тус шалгарсан.

Засгийн газрын 2009 оны 05 дугаар тогтоол, Биеийн тамир, спортын газрын 2019 оны төлөвлөгөө, Дорноговь аймгийн 2019 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу 2019 оны 05 дугаар сарын 29-ний өдөр “Спорт ба хөгжил” зүүн бүсийн сургалтыг зохион байгуулж, сургалтад Дорноговь, Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Говьсүмбэр аймгийн биеийн тамир, спортын салбарын нийт 80 гаруй хүний төлөөлөл хамрагдсан.

Аймгийн эдийн Засаг нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд хүрээнд Дорноговь, Говьсүмбэр аймгийн хамтарсан “Тогтвортой хөгжил-Соёл урлаг” зөвлөгөөнийг зохион байгуулж 180 гаруй соёл, урлагийн салбарын удирдлага, албан хаагчид хамрагдсан.

Боловсрол соёл, урлагийн газар:

Зорилтот арга хэмжээний хэрэгжилтийн явц: ЭЕШ-ын Монгол хэлбичгийн шалгалтын дүнд урьдчилсан байдлаар нэгтгэн анализ хийв. Аймгийн хэмжээнд 2019 онд төгсөж буй 293 сурагч уг

шалгалтад хамрагдсанаас 5 нь буюу 1,7% нь босго оноондоо хүрсэнгүй. 288 нь буюу 98,3% нь энэ жилдээ их дээд сургуульд элсэх боломжтой боллоо.

БНСУ-ын КОЙКА байгууллагаас Дорноговь аймгийн Боловсрол соёл урлагийн газарт 30000\$ -ын өртөг бүхий “ СУРГАЛТ, МЭДЭЭЛЛИЙН ТӨВ”-ийг байгуулж 2019.04.30 ны өдөр нээлтээ хийлээ.

ЭЕШ-ын бэлтгэл ажлын хүрээнд 12-р ангийн сурагчдын дунд зохион байгуулагдаж байгаа математикийн хичээлийн "Дэвжээ-4" тэмцээн Айраг сумын ЕБС дээр 2019-04-27-ны өдөр зохион байгуулагдаж 7 сургуулийн багш, сурагчид оролцож багийн дүнгээр Сайншанд 2-р сургууль 1-р байр, Замын-Үүд 1-р сургууль 2-р байр, Айраг ЕБС 3-р байр эзэлж МУГавьяат багш Б.Бадарч, Б.Мөнхбаяр багш нар сургалт явууллаа.

Дорноговь аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөө хамтдаа” үйл ажиллагааны хөтөлбөр, “Маргаашийн нар багшийн гар дээр мандана” багш нарыг чадваржуулах дэд хөтөлбөрийн хүрээнд багш арга зүй, мэдлэг чадварыг дээшлүүлэх, харилцан бие биеэсээ туршлага судлах, түгээх зорилгоор цэцэрлэгийн багш нарын дунд “Ур чадвар”-ын уралдааныг 3 үе шаттайгаар зохион байгуулж 1 дүгээр шатнаас шалгарсан 31 багш 2-р шатны уралдаанд оролцож, 9 багш 3 шатны уралдаанд амжилттай оролцож Сайншанд сумын 11-р цэцэрлэгийн дуу хөгжмийн багш Д.Наранзул 1-р байр, Сайншанд сумын 10-р цэцэрлэгийн багш Э.Болдмаа 2-р байр, Замын-үүд сумын 3-р цэцэрлэгийн багш Б.Отгонсүрэн 3-р байруудыг тус тус эзэлсэн. Дорноговь, Говь-Сүмбэр аймгийн 180 соёлын ажилтнуудын зөвлөгөөнийг 2019.05.03 нд зохион байгуулллаа.

Аймгийн 9жилийн сургалттай сургуулийн захирал сургалтын менежер нийгмийн ажилтан багш нарын дунд "Орон нутгийн сургуулийн шинэчлэл" аймгийн зөвлөгөөн зохион байгуулагдаж Хөвсгөл сумын багш нар Шинэ монгол сургуулийн үйл ажиллагаанаас орон нутгийн сургуульд хэрэгжүүлж болохуйц 8 үйл ажиллагааг өөрийн сургуульд тохируулан амжилттай хэрэгжүүлсэн арга туршлагаа танилцууллаа. Бусад сургуулийн удирдлага багш нар ямар үйл ажиллагааг нь өөрсдийн сургууль дээрээ хэзээнээс хэрхэн хэрэгжүүлэх тухайгаа ярьж хэлэлцэн бүх 9 жилийн сургалттай дунд сургуулиуд үйл ажиллагааны чиглэлээ гаргасан ажил хэрэгч үр дүнтэй зөвлөгөөн болж өндөрлөлөө. Зөвлөгөөний үеэр УИХ-ын гишүүн Б.Дэлгэрсайхан Хөвсгөл сумын ЕБС-д шинэ фургон машин гардуулан өглөө. Зөвлөгөөнд 50 гаруй багш, 10 захирал оролцсон

БСУГ-ын даргын баталсан “Аймгийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, соёлын төвүүдэд ажиллах удирдамж”-ийн дагуу 5 сард Сайншанд сумын 1,2,3,5-р сургууль, Өргөн, Эрдэнэ, Замын үүд сумын 9 сургууль, 21 цэцэрлэг, 3 сочлын төвийн үйл ажиллагаанд үнэлгээ дүгнэлт өгөх, дэмжлэг үзүүлэх, орон нутгийн иргэдийг мэдээллээр хангах ажлууд хийгдлээ.

Шинэ Монгол сургуулиас ЭЕШ-д бэлтгэх урьдчилсан сорилгийг 7 судлагдахуунаар зохион байгуулж, Математик-172, Нийгэм-185, Англи хэл-139, Физик-75, Биологи-39, Хими-40, Монголхэл - 180 нийт давхардсан тоогоор 830 сурагч хамрагдлаа. Анализ дүгнэлтийг сурагч бүрээр, хичээл бүрээр, сургууль бүрээр гарган сургуулиудад хүргүүлсэн.Энэхүү сорилгыг зохион байгуулахад Аймгийн ЗДТГ-аас 1697100 төгрөгөөр санхүүжүүлсэн.

“ЭХ ХЭЛ-БИДНИЙ ӨВ СОЁЛ” дэд хөтөлбөрийн хүрээнд БСУГ-аас Дорноговь аймгийн хүүхдийн цэцэрлэгүүдийн дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “ЧЭЭЖ ЭРДЭМ” уралдааныг 2019 оны 05-р сарын 24-ны өдөр ЕБ-ын 1-р сургуулийн урлаг танхимд амжилттай зохион байгууллаа. Уг тэмцээний 1-р шат цэцэрлэг тус бүр дээр зохион байгуулагдаж, төрийн 31, төрийн бус 1 цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн 756 хүүхэд хамрагдаж, 2-р шатанд цэцэрлэг тус бүрээс

шалгарсан шилдэг 1 хүүхэд нийт 31 хүүхэд өрсөлдөж мэдлэг оюунаа дайчилан амжилттай оролцлоо.

5 сарын 27-30-ны өдрүүдэд 5-р ангийн монгол хэл, 9-р ангийн монгол хэл, 12-р ангийн монгол хэл, 5-р ангийн математик, 9-р ангийн монгол хэлний шалгалт зохион байгууллаа. 5 сарын 31-нд 5-р ангийн хүн байгаль, 12-р ангийн математикийн шалгалт явагдана. Шалгалтын үед аймгийн төвийн сургуулиудад БСУГ-ын мэргэжилтнүүд хөндлөнгийн хяналт тавьж ажиллалаа. Шалгалтын дүнгээр:

Цаг үеийн ажлын мэдээлэл:

Сайншанд сумын 1,2,3,5 болон Зүүнбаянгийн сургуулийн 12-р ангийн сурагч, анги удирдсан багш нарын дунд Сайншанд сумын ЗДТГ-аас зохион байгуулж буй “Хөгжлийн түүчээ” уулзалтад элсэлтийн ерөнхий шалгалтын талаар мэдээлэл өгөв.

2019 оны 5 сарын 3 ны 14 цагаас БСШУЯ-наас хөрөнгө оруулалт, худалдан авах үйл ажиллагаа, “Би багш” телевизийн зорилтот нэвтрүүлгийн шалгаруулт зэрэг цаг үеийн асуудлаар видео хурал зохион байгуулсан.

Нийслэлийн иргэдийг гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төвийн сургалтанд ахлах ангийн 170 сурагчийг хамруулав.

Хамрын хийдэд Аймгийн БОАЖГ, " Их нартын хад" байгалийн цогцолборт газар, БСУСГ, УЦУОШГазар хамтран ЕБС-ийн сурагчдын дунд " НОГООН ПАСПОРТ" аяны сургалтыг зохион байгууллаа. Тус арга хэмжээд Ерөнхий боловсролын 18 сургуулийн Эко клубудирдсанбагш, сурагчид, сумдын Байгаль орчны мэргэжилтнүүд, холбогдох байгууллагын албан хаагчид оролцлоо.

БСШУСЯам, Сангийн яам хамтран зохион байгуулсан Боловсролын салбарын "Санхүүгийн ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх" сургалтанд 3 хоногийн хугацаатай Дорноговь аймгийн Боловсрол соёл урлагийн газрын 34 санхүүгийн ажилтан, нягтлан бодогч нар хамрагдлаа,

Насан туршийн боловсролын үндэсний төв, Монгол улсын боловсролын их сургуультай хамтарсан зайны сургалтыг 2019 оны 5 сарын 24 ны өдрийн 10-13 цагт хийж, НТБ-ын тулгамдсан асуудал, багш нарын мэргэжил дээшлүүлэх асуудал, иргэдийн тасралтгүй боловсролын чанар хүртээмжийг дээшлүүлэх талаар 21 аймагтай харилцан туршлага солилцож санал бодлоо хуваалцлаа.

“Автомашингүй, архигүй, тамхигүй өдөр”, “Боловсролын салбарын танилцуулга өдөрлөг”-ийг зохион байгууллаа.

“МИНИРОБОТ-2019” тэмцээн 3 дахь жилдээ амжилттай явагдлаа. Тус тэмцээнд Дорноговь аймгийн Сайншанд сумын 1, 2, 3, 5 дугаар сургууль, Замын Үүд сумын 2, 3 дугаар сургууль, Айраг сумын сургуулийн 53 багийн 106 сурагч өөрсдийн зохион бүтээсэн роботоороо өгөгдсөн даалгаврыг гүйцэтгэх зарчмаар тэмцээнд оролцлоо.

Эрүүл мэндийн газар:

“Осол гэмтлийн өнөөгийн байдал, салбар хоорондын хамтын ажиллагаа “ сэдэвт аймгийн зөвлөгөөнийг зохион байгуулж аймгийн ИТХ, ЗДТГ, ГССҮТ, ЭМГ, ГХУСАЗСЗ, ЦГ, ГБХЗХГ, сумдын Засаг дарга, ЭМТ-ийн дарга, аймгийн Нэгдсэн эмнэлгийн төлөөлөл нийт 45 хүн оролцлоо. Зөвлөгөөний явцад осол гэмтлийг бууруулахад салбар хооронд хэрхэн ажиллах талаар харилцан санал солилцож, аймгийн Нэгдсэн эмнэлэг, ГССҮТ хамтран ажиллах гэрээ байгуулж, аймгийн Нэгдсэн эмнэлгийн Мэс заслын тасгийн үйл ажиллагаатай танилцлаа. Осол гэмтлээс урьдчилан

сэргийлэх сэдвийн хүрээнд онол практикын хурал болж нийт 9 илтгэл тавигдсанаас ЭМГ, УАУРСТ, Сайхандуланаан сумын илтгэлүүд шалгарч Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдлаа.

Эмч эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, ур чадвар, ёс зүй харилцаа хандлагыг сайжруулах, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх, эмнэлгийн тусламжийн чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор “Эх хүүхдийн тусламж үйлчилгээг сайжруулъя” ажил мэргэжлийн уралдааныг бүсчилэн 3 үе шаттайгаар амжилттай зохион байгууллаа. Ажил мэргэжлийн уралдаанд хүүхдийн эмч, эх барихын эмч, багийн эмч, эх баригч, сувилагч, НЭМ-ийн ажилтнуудын эх хүүхдийн тусламж үйлчилгээний чадавхийг үнэлэх онол, гардан үйлдлээр мэдлэгээрээ өрсөлдсөнөөс анхан шатны 17 ЭМБ-уудаас 1-р байранд Мишээлт мана ӨЭМТөв, 2-р байранд Эрдэнэ сумын ЭМТ, II дахь шатлалын эмнэлэгээс Аймгийн нэгдсэн эмнэлэг 1-р байрт тус тус шалгарлаа

Явуулын амбулаторийн үзлэг, шүдний эмчийн явуулын үзлэг сумдад тус тус ажиллаж байна.

“Эх, хүүхдийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулъя” сэдэвт эмнэлгийн мэргэжилтнүүдийн дунд зохион байгуулсан ажил мэргэжлийн уралдааны сүүлийн шатны шалгаруулалт болж Эрдэнэ, Хөвсгөл, Мишээлт мана, аймгийн Нэгдсэн эмнэлгийн багууд оролцож анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудаас Мишээлт мана өрхийн эрүүл мэндийн төв, лавлагаа шатны байгууллагуудаас аймгийн Нэгдсэн эмнэлэг тус тус шалгарч Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдлаа.

АШУҮИС-тай хамтран аймгийн нэгдсэн эмнэлэг дээр “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн болон эрх зүйн зөрчил, түүний шалтгаан сэргийлэх арга зам” сэдэвт сургалтыг зохион байгуулж нийт 150 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд хамрагдлаа.

Монголын гэр бүлийн сайн сайхны нийгэмлэг”, “У-PEER Mongolia” ОУБ-тай хамтран нөхөн үржихүйн эрүүл мэндийн “Үе тэнгийн сургагч багш” бэлтгэх сургалт 04 сарын 27-29-ны хооронд зохион байгууллаа. Нийт 24 цагийн багц сургалтанд ерөнхий боловсролын 1, 3, 5-р сургууль, МСҮТ-ийн сурагч, оюутнууд идэвхитэй оролцож, 20 үе тэнгийн сургагч багш шинээр бэлтгэгдсэн.

НҮБ-ын Хүн амын сан, Люксембургийн Их вант улсын санхүүжилттэй Эх, нярайн зайн оношилгооны төслийн хүрээнд Дорноговь аймгийн нэгдсэн эмнэлэгт эх барихын яаралтай тусламжийн сургалтын болон зайн оношилгооны шууд холболтын тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгөх үйл ажиллагаа 5 сарын 01-ний өдөр зохион байгуулагдлаа. Нийт 65 сая төгрөгийн тоног төхөөрөмж хүлэн авч, эх барих, эмэгтэйчүүдийн эмч, эх баригч, нярайн эмч нар эх барихын яаралтай тусламжийн өртөөчилсөн сургалтанд хамрагдаж, мэдлэгээ дээшлүүлэв.

Дорноговь аймгийн нэгдсэн эмнэлэгт “ЭНЕРЖИ-РЕСУРС” ХХК-ийн хөрөнгө оруулалтаар “ЭРҮҮЛ ҮРС - ГЭРЭЛ ИРЭЭДҮЙ” ТТБ-ын гүйцэтгэлтэй нярайн тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай 78.3 сая төгрөгний 14 төрлийн 24 ширхэг тоног төхөөрөмжийг 2019 оны 05 сарын 10 өдөр гардуулж, нярайн эрт үеийн тусламж үйлчилгээг сайжирч, 5 хүртлэх насны эндэгдэл буурах боломжтой болж байна.

Багийн эмч нарын мэдлэг чадавхийг нэмэгдүүлэх орон нутгийн сургалтыг 2019 оны 05 сарын 07-нд зохион байгуулж, 13 сумын 46 эмч мэргэжилтэнг хамрууллаа. Сургалтаар багийн эмчийн ажлын байрны тодорхойлолт, ажлын үр дүнгийн шалгуур үзүүлэлт, анхан шатны маягт

хөтлөлт, цахим мэдээллийн программын танилцуулга зэрэг мэдээллүүд хийж, нэгдсэн эмнэлгийн зөвлөх эмч, тасгийн эрхлэгч нар мэргэжлийн чиглэл чиглэлээрээ орчин үеийн эмчилгээ оношилгооны чиг хандлагаар сургалт хийж хөдөөгийн эмч нарыг чадавхжуулав

ЭМГ-ын даргын 2019 оны А/43 тушаалаар сум, өрхийн эмч нарын ажлын байранд дадлагажуулах сургалтыг 05-06 сард зохион байгуулж, 4 сум 2 өрхийн нийт 6 эмч хүүхдийн болон яаралтай тусламжийн тасагт ажлын байрны дадлага хийж, зайлшгүй эзэмшвэл зохих гардан үйлдэл, бусад оношилгоо эмчилгээний мэдлэгээ сэргээн дадлагажиж байна.

Олон улсын сувилагч нарын өдрийг угтан “Нийгмийн эрүүл мэндэд сувилагч бидний оролцоо” уриан дор 1 сарын аяныг зохион байгууллаа. аяны хүрээнд:

Үйлчлэх хүрээний 1488 айл өрхүүдийн эрүүл амьдрах хэв шинжид үнэлгээ хийхэд Эрүүл мэнд, эдийн засаг, байгальд ээлттэй айл 51.8%, Зөв зан үйлээ хэвшүүлэх шаардлагатай айл 36.2%, Эрүүл мэнд, эдийн засаг, байгальд орчинд халтай зан үйлээ өөрчлөх шаардлагатай айл 12% байв. Эрүүл зөв амьдрах дадлын талаар 1678 хүнд сургалт хийж 3 төрлийн 2878 гарын авлага тарааж эрүүл мэнд, эдийн засаг, байгальд ээлттэй айлуудыг сурталчилсан. “Цэвэр гар-Эрүүл амьдрал” гар угаах челленж, “Цэвэр гар бидний ирээдүй” хөгжимт хөдөлгөөн тэмцээнүүдийг зохион байгуулж сургууль цэцэрлэгийн 78 хүүхдийг оролцуулан гар угаах дадалд сургасан.

Гэр хорооллын болон малчин 445 өрхөд гар угаах үлгэрчилсэн загвар, гар угаах цомогийг сурталчилан, сургалт явуулж 748 ширхэг тараах материал тараасан, хөдөөгийн багийн зорилтот бүлгийн 48 өрхийг сонгон гар угаах цомог өгч 5 өрхийн угаалтуурыг шинэчилж иргэдийн эрүүл амьдрах орчныг дэмжин ажилласан.

Ундны усны эрүүл ахуй, хуванцар савны хэрэглээ, хор уршигийн талаарх сургалт сурталчилгааг 1271 өрхөд хийж, стандартын бус саванд хэрэглэхийг хориглосон тэмдэглэгээ тавьж, шаардлага хангасан савыг сурталчилж 5 сумын Засаг даргын тамгын газар, эрүүл мэндийн зөвлөлтэй хамтран сумдад үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгжүүдтэй гэрээ байгуулан зориулалтын усны савыг ард иргэдэд түгээх гэрээт борлуулагч болгон батламж гардуулсан.

Сувилагч нар өөрийн болон аж ахуй нэгж, албан байгууллага, айл өрхийн хөрөнгөөр нийт 231 айлыг ундны ус хадгалах, зөөвөрлөх стандартын шаардлага хангасан савтай болгосон

СУВИЛАГЧИЙН НЭГ ӨДӨР” мэргэжилээ сурталчилах нээлттэй хаалганы өдөрлөгийн хүрээнд: Би сувилагч” сувилагчийн хишиг өдөр, сувилагч мэргэжлийн ажлын онцлог үнэ цэнийг ойлгуулах ЕБС-ийн хүүхдүүдэд “сувилагч мэргэжил яагаад сонирхолтой вэ” өдөрлөг, 18 нэр төрлийн “Хүүхдийн хоолны үзэсгэлэн”, Хөдөлгөөн эрүүл мэнд сэдвийн хүрээнд заавал сурах 10 бүжгийг иргэдэд зааж бүжгийн тэмцээн зэрэг уралдаан тэмцээн, өдөрлөгийг 16 байгууллага 527 иргэдэд 17 төрлийн үйлчилгээг үзүүлж, 28 төрлийн 728 гарын авлага тараасан

Монголын сумын эмч мэргэжилтэнүүдийн холбоотой хамтран “Сүрьеэгүй ирээдүйн төлөө хамтдаа” сургалтыг 2019 оны 05 дугаар сарын 08-нд зохион байгуулж, 13 сумын 50 эмч, удирдлагуудыг хамруулан сүрьеэ өвчний өнөөгийн байдал, хяналт, хавьтлын сэргийлэлт, эрт илрүүлэлт, үйлчлүүлэгч төвтэй сүрьеэгийн тусламж үйлчилгээ, сорьц цуглуулах, хадгалах, тээвэрлэх менежмент, анхаарах асуудлуудаар мэдээлэл хийж эмч нарыг чадавхжууллаа.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/247 дугаар захирамжийн дагуу аймгийн Мэргэжилтний багийн нэрэмжит гар бөмбөгийн тэмцээнийг 05 сарын 12-нд зохион байгууллаа. Тэмцээнд Сайншанд, Өргөн, Замын-Үүд, Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг сумын 10 баг өрсөлдөж Өргөн, Хөвсгөл, Хатанбулаг сумдын баг эхний байруудыг эзэллээ. Тэмцээнд оролцох багийн бүрэлдэхүүнд орсон сумын Мэргэжилтний багийн гишүүд - 12, Сайншанд сумын багийн хэсгийн ахлагч, Нийгмийн ажилтнууд -20 хүнд тус тус Улаанбаатар хотын албадан эмчилгээний төвийн донтолтын мэргэжлийн эмч Түвшинжаргалыг урьж авчран зорилтот бүлгийн иргэдэд мэдээлэл өгөх арга зүйн талаар сургалт зохион байгууллаа.

Аймгийн ИТХ, Сайншанд сумын ИТХ, аймгийн ХБИ-ийн нэгдсэн холбоо хамтран зохион байгуулсан Нарны баярт оролцогч 57 хүнд Мэргэжилтний баг, АА-ын ач холбогдол, Эрт илрүүлэгийн үзлэгт хамрагдах нь, БЗДХ-аас сэргийлэх арга зам зэрэг сэдвүүдээр мэдээлэл хийж, ярилцлага хийлээ.

“Улаанбурхан өвчинд цэг тавья” уриатай дархлаажуулалтын 10 хоногийн хүрээнд “Нэмэлт дархлаажуулалтын арга зүйн сургалтын зохион байгуулж 19 эрүүл мэндийн байгууллагын эмч мэргэжилтнүүд , МСҮТ, АШУҮС-ийн Дорноговь салбар сургуулийн эмч, нийгмийн ажилтан 40 хүнийг хамруулсан. “Нэмэлт дархлаажуулалтанд хамруулах тухай” Аймгийн Засаг даргын А/446 дугаар захирамжаар ажлын хэсгийг байгуулан үйл ажиллагааны зардалд 1999,6 мян. төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлээ.

“Улаанбурхан өвчинд цэг тавья” уриатай дархлаажуулалтын 10 хоногийн хүрээнд 10-18насны хүн амыг улаанбурхан улаануудын нэмэлт дархлаажуулалтанд хамруулах ажлыг зохион байгуулж 9672 хүн хамруулахаас 8799 хүнийг хамруулж хамралтыг 90.9%-д хүргэсэн. Нэмэлт дархлаажуулалтын талаар DSB телевизээр мэдээлэл өгсөн.

Дархлаажуулалтын үйл ажиллагаанд түргэвчилсэн үнэлгээ хийн Сайншанд сумын 4 сургуулийн 10 ангийн 330 хүүхдүүдийг үнэлгээнд хамруулахад 6 хүүхэд огт хийлгээгүй байсан бөгөөд хоцорсон хүүхдүүдийг нөхөн дархлаажуулах төлөвлөгөөг сургуулиуд гарган ажиллалаа.

Монголын сумын эмч мэргэжилтний холбооны дэмжлэгтэйгээр Сайншанд суманд Артерийн даралт, Чихрийн шижин, В, С вирус илрүүлэх шинжилгээ, БЗДХ болон Сүрьеэ өвчний эрт илрүүлэг үзлэг шинжилгээг зохион байгуулж эхний ээлжинд 1,3, 6-р багийн 159 иргэн хамрагдаад байна.

“Осол гэмтлийн шалтгаан, нас баралт, Гэмтлийн үед үзүүлэх анхны тусламж, “Бэлгийн замаар дамжих халдварын өнөөгийн байдал, урьдчилан сэргийлэлт” зэрэг сэдвүүдээр “Шунхлай говь” ХХК-ийн нийт 25 ажилчдад сургалт зохион байгууллаа.

“Амны хөндийн эрүүл мэнд”, “Гэр бүл төлөвлөлт” сэдвээр 5-р сургуулийн багш, ажилчдад сургалт зохион байгуулж, 53 багш, ажилчдад эрүүл мэндийн боловсрол олголоо.13-р цэцэрлэгийн дунд, ахлах бүлэг , 3-р сургуулийн 4а ангийн нийт 61 хүүхэд, 7 эцэг эхэд амны хөндийн эрүүл ахуй сахих талаар мэдээлэл өгсөн.

Жирэмсний сургалтаар жирэмсэн эхүүдэд зөвлөгөө өгч, СДЗШ-ний талаар сурталчилгааны материал тараав. Сургалтанд нийт 39 жирэмсэн эх хамрагдсан ба Жирэмсэн эхэд зориулсан сургалт “Жирэмсэн үед илрэх шинж тэмдэг ба төрөлтөд бэлдэх үйл явц” “Сүрьеэ өвчинөөс

сэргийлье”, ”Жирэмсэн үеийн хооллолт” сэдвээр, анхан төрөгч ээжүүддээ зориулан нярай хүүхдийн хамрыг цэвэрлэх дадлага хичээл орлоо.

Сайншанд сумын ЕБ-ын 1 дүгээр сургуулийн 8-9 дүгээр ангийн сурагчдад “Бэлгийн ариун цэвэр, Бэлгийн замаар дамжих халдвар, түүнээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалт зохион байгуулж, 210 сурагч, Дотуур байрны 54, Мөн цагдаагийн газрын 41 ажилтан албан хаагчдад мэдээлэл хийлээ.

Орон нутгийн гэрээт DTV хэвлэлийн байгууллагатайгаа хамтран “Давсгүй хоол-Эрүүл мэнд” цуврал хичээл-2 бичлэгийг хийж, зочны цаг буланд АШУҮИС-ийн НАС-ын сургуулийн багш Ж.Отгонболд уригдан Эрүүл шүд-Эрүүл хүүхэд хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар мэдээлэл хийв.

Амны хөндийн кабинетаар дамжуулан 8 удаагийн сургалтыг зохион байгуулж, 10-р цэцэрлэгийн 114 хүүхдэд, 10 эцэг эхэд амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгосон.

Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” хөтөлбөрийн хүрээнд эрүүл мэндийн даатгалтай гэрээ байгуулсан хувийн хэвшлийн 5 шүдний эмнэлэг 4 сараас эхлэн 02-12 насны хүүхдүүдэд амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг, эмчлэн эрүүлжүүлэх ажлыг эхлүүлэн ажилласнаар 5 дугаар сарын байдлаар эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр нийт 1080 хүүхдийг үзлэгт хамруулж, эрүүлжүүлээд байна. Шүдний нарийн мэргэжлийн эмчийн тусламж, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын баталсан захирамжийн дагуу 7 суманд явуулын шүдний эмчийн үзлэг хийхээс 5 суманд нийт 993 хүнийг хамруулж, 635 өвчлөл илрүүлэн, 820 шүдийг эмчлэн эрүүлжүүлээд байна.

“Амны хөндийн эрүүл мэнд”, “Гэр бүл төлөвлөлт” сэдвээр 5-р сургуулийн багш, ажилчдад сургалт зохион байгуулж, 53 багш, ажилчдад эрүүл мэндийн боловсрол олголоо.13-р цэцэрлэгийн дунд, ахлах бүлэг , 3-р сургуулийн 4а ангийн нийт 61 хүүхэд, 7 эцэг эхэд амны хөндийн эрүүл ахуй сахих талаар мэдээлэл өгсөн.

Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс:

Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын чиглэлээр:

Аймгийн хэмжээнд хэрэгжиж байгаа болон дунд хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төслүүдийн талаарх мэдээллийг нэгтгэж, Үндэсний хөгжлийн газарт албан бичгээр хүргүүлсэн.

Орон нутгийн төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд холбогдох саналыг өгч ажилласан.

Барилга угсралтын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл авсан ААН-ийн судалгаа, аймаг, сумдын орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдсэн төсөл, арга хэмжээний судалгааг нэгтгэж, Татварын хэлтэст хүргүүлсэн.

Дорноговь их хөгжил санд зарим байгууллагаас ирсэн хөрөнгө оруулалтын шинжтэй саналуудыг нэгтгэж хүргүүлсэн.

Аймгийн Засаг дарга аймгийн төвд хийгдэж буй бүтээн байгуулалтын ажилтай танилцаж газар дээр асуудлыг шийдвэрлэж ажиллалаа. /Авто зам, зогсоол, Иргэдийн

хөгжлийн төв, 320 хүүхдийн бага сургууль, Цэвэрлэх байгууламж, спорт талбай тоглоомын талбай, 50 ортой эмнэлэг/

Шинэ хөдөө төслийн хүрээнд нийлүүлсэн зарим фургон автомашиныг хүлээн авч, сумдад хүргүүллээ.

Аймгийн Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авч буй 4 ширхэг автобусыг хүлээн авч, холбогдох бичиг баримтыг бүрдүүлсэн.

Аймгийн ЗДТГ-ын засварын ажлын гүйцэтгэгч “Эм ти эм жи” ХХК-ийн гэрээг цуцлах тухай зохиогчийн хяналтын дүгнэлтийг үндэслэн аймгийн Засаг даргын захирамж гаргаж, гэрээг цуцалж, “Төгс-Өнөд” ХХК-иар гүйцэтгүүлж байна.

Даланжаргалан сумын төвлөрсөн дулаан, шугам сүлжээний ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Илчит сансар” ХХК, Хатанбулаг сумын төвлөрсөн дулаан, шугам сүлжээний ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Одкон холдинг” ХХК, Мандах сумын Соёлын төвийн засварын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Мөнх хялмаа” ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй Иххэт сумын нийтийн орон сууцнуудын засварын ажлын санхүүжилтийг Сангийн яаманд уламжилж, санхүүжилтийг олгосон.

Хатанбулаг, Эрдэнэ сумдын төвлөрсөн шугам сүлжээний ажлын зураг төсвийн гүйцэтгэгчээр шалгарсан Монкуз басс ХХК-ийн санхүүжилтийг олгуулахаар Сангийн яаманд хүсэлт явуулсан.

Сайншанд суманд баригдах 1000 хүний суудалтай Спорт цогцолборын барилгын гүйцэтгэгчээр шалгарсан Болор аграмба ХХК-ийн урьдчилгаа санхүүжилтийг олгуулахаар гүйцэтгэлийн болон урьдчилгаа төлбөрийн баталгааг гаргуулж, Сангийн яаманд уламжилсан.

Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөгөөнд тусгуулахаар сумдаас ирүүлсэн саналуудыг нэгтгэж байна.

Замын-Үүд сумын Халуун усны барилга, Сайншанд сумын 5-р багийн Багийн төвийн барилга, Сайншанд, Замын-Үүд сумдыг ЕБС-ийн турникет систем суурилуулах зэрэг ажлын гэрээг байгуулсан.

Барилга, хот байгуулалт, газрын харилцааны чиглэлээр: Замын-Үүд суманд Чөлөөт бүсийг байнгын үйл ажиллагаанд оруулахтай холбоотой “Замын-Үүд” чөлөөт бүсийг 2019 онд байнгын үйлажиллагаанд оруулах бэлтгэл ажлын хүрээнд төр, хувийн хэвшлийн үйл ажиллагааг жигдрүүлэх,чөлөөт бүсийг хөгжүүлэх төрийн бодлого шийдвэрийг танилцуулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон барилгын ажлын зөвшөөрөл, барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах талаар зөвлөмж өгөх чиглэлээр төр, хувийн хэвшлийн уулзалт семинарыг Чөлөөт бүсийн захирагчийн албатай хамтран зохион байгууллаа. Уулзалт семинарт Дорноговь аймгийн Засаг даргын тамгын газар, Замын-Үүд дахь Гаалийн газар, Хилийн 0108-р анги, Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Дорноговь аймгийн Онцгой байдлын газар, Дорноговь аймаг дахь Гадаадын иргэн,

харьяатын газар, “Замын-Үүд” чөлөөт бүсэд газар эзэмшигч аж ахуй нэгжийн нийт 50 гаруй төлөөлөл оролцож, мэдээ мэдээлэл авч, харилцан санал солилцов.

Сайншанд сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт Бат-Ур компанийн барьж байгаад орхисон орон сууцны барилгатай холбоотой асуудлаар СХД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд гуравдагч этгээдээр оролцож тайлбар өгсөн.

Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспоржуулах журмын төсөлд оруулах саналыг боловсруулж БХБЯ-нд хүргүүлсэн.

Мандах суманд баригдах цэцэрлэгийн асуудлаар Сангийн яаманд санал хүргүүлсэн.

50 ортой төрөх эмнэлгийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгч Баярсконстракшн ХХК-д албан шаардлага мэдэгдэл хүргүүлсэн.

Тендерийн үнэлгээний хороонд ажиллаж холбогдох үнэлгээг хийсэн.

Аймгийн Засаг даргын А/400 дугаар захирамжаар Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн мэдээлэл бүрдүүлэх зохион байгуулах ажлын хэсэг байгуулж холбогдох агентлагт үүрэг чиглэл өгсөн

Барилгын ажлын зөвшөөрөл олголтын судалгаа мэдээллийг гаргаж Татварын хэлтэст хүргүүллээ.

Барилгын ажил эхлүүлэх үргэлжлүүлэх хүсэлтийг хүлээн авч судлан 25 иргэн, ААНБ-д барилгын ажлын зөвшөөрөл олгов.

Их бүтээн байгуулалт-2019 нээлтийн ёслолын үйл ажиллагааны бэлтгэлийг хангуулж, Бүтээн байгуулалтын нээлтийг 8 газарт хийж, Нээлттэй хаалганы өдөрлөг, Хөдөлмөрийн яармагийг Сайншанд сумын төв талбайд зохион байгуулсан. Нээлттэй хаалганы өдөрлөгт ГХБХБГ, НДХ, ОБГ, МХГ, ХХҮГ, Өрхийн эмнэлгүүд, Татварын хэлтэс, Чандмань-Илч ОНӨХК, Хөдөлмөрийн яармагт Монцемент, Сизу, ТОБЭМ, Энержипарагон, Дорно говийн эрдэнэ ХХК, Эн Эйч Си ХХК, Болораграмба, Газрын тос боловсруулах үйлдвэр зэрэг байгууллагууд оролцож иргэдэд мэдээлэл өгөх, ажлын байранд бүртгэх, үйл ажиллагааг явуулж, арга хэмжээнд 100 гаруй иргэд оролцлоо. Өдөрлөгийн үеэр Мегатех ХХК-иас нийгмийн хариуцлагын хүрээнд өгсөн 10 гэрийг нийгмийн халамж шаардлагатай 10 өрхөд олгосон ба аймгийн ЗДТГ-аас газар тариалан эрхлэгч 6 иргэнд хүлэмж гардуулсан. Аймгийн төвд МТ колонк, Нэгдсэн эмнэлэг болон 4 дүгээр багт 2019 онд хийгдэх бүтээн байгуулалтын 3х6 м-ийн хэмжээтэй анонсыг хэвлүүлэн самбарт тогтоолгосон.

Аймгийн Засаг дарга аймгийн төвд хийгдэж буй бүтээн байгуулалтын ажилтай танилцаж газар дээр асуудлыг шийдвэрлэж ажиллалаа. /Авто зам, зогсоол, Иргэдийн хөгжлийн төв, 320 хүүхдийн бага сургууль, Цэвэрлэх байгууламж, спорт талбай тоглоомын талбай, 50 ортой эмнэлэг/

Хөвсгөл, Улаанбадрах сумын хилийн цэсийн асуудлаар аймгийн ИТХТХ-ын 2019 оны 15 дугаар тогтоолоор байгуулагдсан мэргэжлийн комиссыг хуралдаж асуудлыг хэлэлцэн холбогдох сум, агентлагт холбогдох материалыг бүрдүүлэн аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэхэд бэлэн болгох үүргийг өглөө.

Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх ашиглуулах чиглэлээр аймгийн Засаг даргын 5 захирамж шийдвэр гарсан байна.

Байгаль орчны чиглэлээр: Уул уурхай ашиглалт, боловсруулах, баяжуулах үйлдвэрийн хөгжлийг дагаад байгаль орчин, хүний эрүүл мэнд, ард иргэдийн амьдрах орчин, малын бэлчээрт үзүүлэх сөрөг нөлөөлөл нэмэгдэж байгаатай холбогдуулан Цагдаагийн ерөнхий газраас зарлан явуулж буй “Бодис-2019”, “Байгалиа хамгаалъя” аяны хүрээнд байгаль орчин, геологи уул уурхайн салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмал олборлох, боловсруулах, бичил уурхайн чиглэлээр ажиллаж байгаа аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг аймгийн Засаг даргын 2019 оны А/426 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг Айраг, Даланжаргалан сумдад ажиллаж байна. Ажлын хэсэгт *Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Умард говийн гүвээт халхын дундад талын сав газрын захиргаа, Автотээврийн төв, Тагнуулын хэлтэс, Гадаадын иргэн харьяатын газар, Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Холбогдох сумдын ЗДТГ-ын мэргэжилтэн нар оролцож байна.*

Зэрлэг ан амьтан, Аргаль хонь, Хулан адуу, Хар сүүлтий, Цагаан зээрийн нүүдлийн замыг нээх чөлөөлөх зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Зам тээвэр хөгжлийн яам, ШУА-ын ерөнхий болон сорилын биологийн хүрээлэн, Байгаль зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг, Оюутолгой ХХК, Улаанбаатар төмөр зам хамтран тус аймгийн Эрдэнэ сумын нутаг дэвсгэрт 1.5 км төмөр замын тор, шонг авч, хөдөлгөөн мэдрэгч камер суурилуулсан.

Аймгийн аялал жуулчлалын мастер төлөвлөгөө боловсруулах ажлын 2 дахь шатны хэлэлцүүлгийг 20-ны өдөр зохион байгуулна.

2019 оны 05 дугаар сарын 09-ний өдөр Хамарын хийдэд “Ногоон паспорт” арга хэмжээг зохион байгуулсан. Тус арга хэмжээнд Ерөнхий боловсролын 18 сургуулийн Эко клубын багш, сурагчид, 13 сумын Байгаль орчны бодлогын мэргэжилтэн, Ус, цаг уур орчны шинжилгээний төв, Галбө-Өөш Долоодын говийн сав газрын захиргаа, Боловсрол, соёл урлагийн газар, Эрүүл мэндийн газрын холбогдох мэргэжилтэн нийт 145 хүн хамрагдсан.

Эрдэнэ суманд үйл ажиллагаа явуулдаг “Эрдэнэ хун уул” нөхөрлөл болон Айраг суманд үйл ажиллагаа явуулдаг “Дорноговийн үйлс” ХХК –д ус ашиглуулах дүгнэлт, Таван толгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын барилга угсралтын ажилд ашиглах худаг гаргах зөвшөөрлийг олгосон.

Бүх нийтээр мод тарих үндэсний өдрийг угтан 09,10-ний өдрүүдэд Сайншанд сум болон бусад сумдад мод тарих бэлтгэл ажлыг хангаж модны нүхээ ухах арга хэмжээг зохион байгуулж 1000 гаруй иргэн оролцсон байна. 11-ний өдөр мод тарих үндэсний өдрийн нээлтийн арга хэмжээг зохион байгуулан БНХАУ-ын ӨМӨЗО-ны Дархан муу

мянганы хошуунаас аймагт 35000 ширхэг мод хандивласныг аймаг, сумдад хуваарилан иргэд, аж ахуй нэгж байгууллагуудад захиалгын дагуу хувиарлан олгосон.

УЦУОШТөвийн дэргэдэх Цаг агаарт зориудаар нөлөөлөх 2 экспетиц 05-р сарын 10,11,12-ны өдөрүүдэд Айраг, Дэлгэрэх, Иххэт сумдад ажиллахаар 2 ажилласан.

Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний чиглэлээр:

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох дэд хороог аймгийн Засаг даргын 2019 оны А/457 дугаар захирамжаар томилсон. Уг дэд хорооны дарга, гишүүд Хэнтий аймагт 2019 оны 05 дугаар сарын 25-ны өдөр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас зохион байгуулж буй сургалтад хамрагдсан. Тус сангаас хөнгөлөлттэй зээл олгох талаарх мэдээллийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр журамд заасан хугацаанд явуулж 2019 оны 05 дугаар сарын 27-оос 2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрийг дуустал хүлээн авахаар ажиллаж байна.

Мал эмнэлгийн ажил, үйлчилгээний 2020 оны зардлыг батлуулахаар Мал эмнэлгийн ерөнхий газарт хүргүүлсэн.

Үндэсний уламжлалт болон орон нутгийн онцлог бүхий хоол, үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх, дэмжих, таниулах, сурталчлах зорилгоор 2019 оны 06 дугаар сарын 05-09-ний өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдах “Чингис хааны цом-2019” олон улсын хоолны фестивальд орон нутгийн төлөөлөл оролцохоор бэлтгэл хангаж байна. Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 900 000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн

Аймгийн хэмжээнд 2019 онд зохион байгуулах хурдан морьдын зуны бүсийн уралдааны тов, уралдах нас, хугацааг аймгийн Засаг даргын 2019 оны А/479 дүгээр захирамжаар баталсан.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/535 дугаар захирамжаар Мандах, Өргөн, Улаанбадрах, Замын-Үүд, Эрдэнэ, Сайншанд сумын үхэр, хонь, ямаанд шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын ажлыг зохион байгуулсан.

Цаг агаарын гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээллийг “Масс мессеж” үйлчилгээ болон цахим мэдээллийн хэрэгслээр малчид, иргэдэд хүргэн ажилласан.

Гэр бүлийг дэмжих жилийн хүрээнд хашаандаа ногоо тарих сонирхолтой Сайншанд сумын зорилтот бүлгийн 6 иргэнд нийлэг хальсан хүлэмж олгосон.

“Дорноговь аймгийн шигшмэл хурд-2019” хаврын бүсийн хурдан морьдын уралдааныг зохион байгуулсан. Алтанширээ сум “Алтан азарга”-ны эзэн болсон.

Аялал жуулчлал, амралтын улирал эхэлсэнтэй холбогдуулан орон нутгийг зорин ирэх жуулчдын тоо өдрөөс өдөрт нэмэгдэж байна. Мөн гадаад, дотоодын томоохон төсөл, хөтөлбөрүүд тус аймагт хэрэгжиж бусад улс, аймаг, Улаанбаатар хотоос ажиллах хүч олноор авч байгаатай холбогдуулан Сайншанд сумын 3 дугаар баг, төв талбай буюу хотын А зэрэглэлийн бүсэд байрлах “Дорноговь” зочид буудал, худалдаа, үйлчилгээний цогцолборын гадна тохижилт, өнгө үзэмжийг сайжруулан, холбогдох хууль, стандартад

нийцүүлэн ойрын хугацаанд хэвийн ажиллагаанд оруулах тухай албан хүсэлтийг Улаанбаатар банканд хүргүүллээ.

Аймгийн хэмжээнд сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, хэрэгжилт, үр дүнгийн байдалд улсын үзлэг зохион байгууллаа. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, цаашид авах арга хэмжээний талаарх саналыг ХХААХҮЯ-нд хүргүүлэхээр ажиллаж байна.

Шинэ хөдөө төслийн хүрээнд нийлүүлсэн зарим фургон автомашиныг хүлээн авч, сумдад хүргүүллээ. Уг төслийн хүрээнд 8 суманд мал угаалгын суурин ванн, жижиг дунд үйлдвэрийн тоног төхөөрөмж, инженерийн хийцтэй худаг, хадлангийн болон газар тариалангийн тоног төхөөрөмж нийлүүлэхээр тендерийн баримт материалыг бүрдүүлэн ажиллаж байна.

Зам, тээвэр, эрчим хүч, харилцаа холбооны чиглэлээр: Зэрлэг ан амьтан, Аргаль хонь, Хулан адуу, Хар сүүлтий, Цагаан зээрийн нүүдлийн замыг нээх чөлөөлөх зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Зам тээвэр хөгжлийн яам, ШУА-ын ерөнхий болон сорилын биологийн хүрээлэн, Байгаль зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг, Оюутолгой ХХК, Улаанбаатар төмөр зам хамтран тус аймгийн Эрдэнэ сумын нутаг дэвсгэрт 1.5 км төмөр замын тор, шонг авч, хөдөлгөөн мэдрэгч камер суурилуулсан.

Их бүтээн байгуулалт-2019 нээлтийн ёслолын үйл ажиллагааны бэлтгэлийг хангуулж, Бүтээн байгуулалтын нээлтийг 8 газарт хийж, Нээлттэй хаалганы өдөрлөг, Хөдөлмөрийн яармагийг Сайншанд сумын төв талбайд зохион байгуулсан. Нээлттэй хаалганы өдөрлөгт ГХБХБГ, НДХ, ОБГ, МХГ, ХХҮГ, Өрхийн эмнэлгүүд, Татварын хэлтэс, Чандмань-Илч ОНӨХК, Хөдөлмөрийн яармагт Монцемент, Сизу, ТОБЭМ, Энержипарагон, Дорно говийн эрдэнэ ХХК, Эн Эйч Си ХХК, Болораграмба, Газрын тос боловсруулах үйлдвэр зэрэг байгууллагууд оролцож иргэдэд мэдээлэл өгөх, ажлын байранд бүртгэх, үйл ажиллагааг явуулж, арга хэмжээнд 100 гаруй иргэд оролцлоо.

Өдөрлөгийн үеэр Мегатех ХХК-иас нийгмийн хариуцлагын хүрээнд өгсөн 10 гэрийг нийгмийн халамж шаардлагатай 10 өрхөд олгосон ба аймгийн ЗДТГ-аас газар тариалан эрхлэгч 6 иргэнд хүлэмж гардуулсан. Аймгийн төвд МТ колонк, Нэгдсэн эмнэлэг болон 4 дүгээр багт 2019 онд хийгдэх бүтээн байгуулалтын 3х6 м-ийн хэмжээтэй анонсыг хэвлүүлэн самбарт тогтоолгосон.

Аймгийн Засаг дарга аймгийн төвд хийгдэж буй бүтээн байгуулалтын ажилтай танилцаж газар дээр асуудлыг шийдвэрлэж ажиллалаа. /Авто зам, зогсоол, Иргэдийн хөгжлийн төв, 320 хүүхдийн бага сургууль, Цэвэрлэх байгууламж, спорт талбай тоглоомын талбай, 50 ортой эмнэлэг/

Сайншандсумын 3-р баг Шунхлай ШТС-аас Петровис ШТС хүртэлх 1.18 км авто зам, Ялалтын гудамжны 230,65 метр авто зам болон Сайншанд сумын ЗДТГ-ын урд талын авто зогсоол, Сайншандсумын 3-р баг Шунхлай ШТС-аас Хаан банк хүртэлх 168 метр авто зам, авто зогсоол, Сайншанд сумын 10-р цэцэрлэгийн гадна авто зогсоолыг асфальтбетон хучилттай болгох шинэчлэх ажлын тендерт ирүүлсэн компанийн төсвийг хянаж орон нутгийн өмчийн газарт өгсөн.

Сайншанд сумын 5-р багийн бохир усны шугам шинэчлэх ажил, Сайншанд сумын 1-р баг Данзанваанчигийн хэсгийн айл өрхийг цэвэр усны шугамд холбох ажлын ажил эхэлүүлэх зөвшөөрөл олгосон.

Дорноговь аймагт мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарт хэрэгжүүлсэн төслийн судалгаа гаргаж, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.

Хууль эрхзүйн хэлтэс:

Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар нийгэмд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааг зохион байгуулах, автомашины хэрэглээнээс татгалзаж, нийтийн тээвэр, унадаг дугуй, явган зорчилт зэрэг автомашинаас бусад ачаалал багатай тээврийн хэрэгслийн хэрэглээг дэмжих, архи, тамхинаас татгалзахыг уриалах зорилгоор Дорноговь аймгийн Сайншанд сумын хэмжээнд 2019 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн Бямба гарагийг “Автомашингүй, архигүй, тамхигүй өдөр” болгон зохион байгууллаа.

Мөн дээрх арга хэмжээтэй хамтатган Сайншанд суманд үйл ажиллагаа явуулж буй Төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаагаа сурталчлах нээлттэй өдөрлөгийг зохион байгуулсан бөгөөд Эрүүл мэнд, соёл, спорт, боловсрол, байгаль орчин, эмэгтэйчүүд, хэвлэл мэдээлэл, эдийн засаг, худалдаа, үйлдвэрлэл, бизнес, хөдөө аж ахуй, сургалт сурталчилгаа, олон нийтийн байгууллага, залуучууд, хүний эрхийн гэх мэт 32 чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 50 гаруй байгууллага оролцож үйл ажиллагаагаа сурталчилсан байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын ХЭЗХ нь харьяа хууль сахиулах чиг үүргийн 10 агентлагуудын хамт “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд иргэдэд эрх зүйн болон хүний эрхийн анхан шатны зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Эрх зүйн боловсролыг-Иргэн бүрт” өдөрлөгийг Айраг, Даланжаргалан, Дэлгэрэх, Иххэт, Алтанширээ сумдад зохион байгуулж 1130 иргэнд үйлчилгээ үзүүлсэн.

Мөн 06 дугаар сарын 03-ны өдрөөс Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг, Мандах, Сайхандулаан сумдад ажиллахаар бэлтгэл ажлыг хангаад байна.

Иргэдийн сайн дурын үндсэн дээр байгуулагдан архинд донтох өвчнийг эдгэрүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй АА болон бусад бүлэгтэй хамтран ажиллах аймаг, сумдын мэргэжилтний багийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах захирамж боловсруулсан танилцуулсан.

1111 төвд Аймгийн Цагдаагийн газарт холбогдуулан Замын үүд суманд гарсан Автобусны ослын талаарх эрүүгийн хэргийн хохирогч нараас ирүүлсэн 2 гомдлыг шийдвэрлэж хариуг хүргүүлэв.

Хууль зүйн туслалцааны төвийн Дорноговь аймаг дахь салбарын улсын өмгөөлөгч нь 2019 оны 05 сарын 31-ны өдрийн байдлаар нийт 23 иргэнд хууль зүйн зөвлөгөө өгсөн.

Аймгийн Цагдаагийн газраас Айраг, Даланжаргалан, Дэлгэрэх, Иххэт, Алтанширээ сумдад архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилж буй 15 байгууллагуудад

шалгалт хийсэн. Мөн Цагдаа, нарын хамтын ажиллагааг шалгаж, заавар зөвлөгөөг өгч ажиллаа.

Архивын тасаг:

Архивын тасагас 2019 оны 05 дугаар сард хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан, Хууль эрх зүйн хэлтсийн даргаар батлуулсан. Төлөвлөгөөнд 33 ажлыг хийхээр төлөвлөж, 78,8 хувьтай биелүүлсэн байна.

Архивын тасаг нь 80 албан бичиг хүлээн авч, 23 байгууллагад 10 албан бичиг явуулсан.

Аймгийн төрийн архивын сан хөмрөгт 2019 онд нөхөн бүрдүүлэлт хийх ажлын график"-ийг дагуу Сайншанд сумын 5,9 дугаар цэцэрлэг, Шуудан үйлчилгээний газар, Холбооны газар зэрэг байгууллагуудаас 330 байнга хадгалах баримт хүлээн авч, акт үйлдэж, хадгаламжийн санд байрлуулсан.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/396 дугаар захирамжаар “ Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийг явуулах аймгийн салбар комиссыг 16 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Улсын үзлэгийн комисс 05 сарын 21-ний өдөр хуралдаж, үзлэгийн бэлтгэл ажлын төлөвлөгөө, Үзлэгт хамрагдах байгууллагуудын жагсаалт, үзлэг явуулах хуваарийг баталж, сумд, байгууллагуудад хүргүүллээ. Сумдын ЗДТГ-ын дарга, аймгийн төвийн төрийн байгууллагуудын хяналт шинжилгээ хариуцсан мэргэжилтэн, архив, бичиг хэргийн ажилтнуудад улсын үзлэгийн талаар сургалт явуулж, чиглэл өгсөн. Улсын үзлэгийн талаар аймгийн телевиз болон ЗДТГ-ын сайтад мэдээлж байна.

Аймгийн хэмжээнд Улсын үзлэг 05 сарын 29-ны өдөр эхэлж, 5 ажлын хэсэг 10 гаруй байгууллагад үзлэг явуулсан.

Аймгийн цагдаагийн газрын алба хаагчдад улсын үзлэгтэй холбогдуулан сургалт явуулж, баримтын тооллого явуулах үйл ажиллагаанд оролцон мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.

Төрийн архивын дэргэдэх БНШАЗК-ын 3 дугаар хурлыг төлөвлөгөөг гаргаж, 12 байгууллагын 35 тоо бүртгэлийн баримт бичгийг комиссын гишүүдээр хянуулж, саналыг авч нэгтгээд байна.

Аймгийн ЗДТГ-ын Архивын тасгийн дэргэдэх ” Байгууллагын архивын баримтыг гэрээгээр цэгцлэх Ажлын хэсэг”ийн архивч нар Айраг сумын Эрүүл мэндийн төвийн архивын баримтад иж бүрэн нягтлан шалгах ажил хийж, данс бүртгэлийг үйлдсэн бөгөөд одоо Айраг сумын ЗДТГ-ын архивын баримтад иж бүрэн нягтлан шалгалт хийж байна.

Аймаг, сумдын 11 байгууллагаас хэвлэмэл хуудасны захиалгыг хүлээн авч, Нийтлэг үйлчилгээний газарт хүргүүлэн, 9 байгууллагын 13 төрлийн хэвлэмэл хуудасны эхийг хянаж, 3820 хуудас хэвлэх зөвшөөрөл олгов.

Аймгийн Архивын тасагт 76 иргэн, 2 байгууллагаас өргөдөл, хүсэлт ирүүлснийг хүлээн авч, 39 архивын лавлагаа, тодорхойлолт олгож, 553 иргэнд 112 архивын баримтын хуулбар олгож үйлчилсэн.

Архивын ерөнхий газраас зохион байгуулсан “Архив, албан хэрэг хөтлөлтийн онол арга з” сэдэвт мэргэжил олгох сургалтад Архивын тасгийн цахим сангийн опероторч Г.Энх-Амар хамрагдсан бөгөөд сургалтын төлбөрт 250000 төгрөг зарцуулсан.

Төрийн 11 байгууллагын архив, бичиг хэргийн ажилтныг хүлээн авч 2019 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт, байнга, түр, 70 жил хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл, Устгах хэргийн актыг хянаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

Архивын сан хөмрөгт хадгалагдаж Худалдаа бэлтгэлийн удирдах газрын 1950-19889 оны архивын баримтад эрдэм шинжилгээний техник боловсруулалт хийж, 427 хн бүрдүүлэн данс, бүртгэлийг шинэчлэн үйлдэв.

Архивын тасгийн цахимжуулалтын ажлын төлөвлөгөөний дагуу Материал техникийн хангамжийн удирдах газар, Анагаах ухааны коллеж зэрэг хөмрөгийн захирамжлалын баримт бичиг программд шивж, цахим мэдээллийн сан үүсгэв. Аймгийн ЗДТГ-ын 23 хн-ийн 4758 хуудас баримтыг фотошоп программын тусламжтайгаар засварлаж ашиглалтын хувь үйлдэв.

Архивын тасгийн цахимжуулалтын ажлын сарын мэдээг Архивын ерөнхий газарт хүргүүлэв.

Аймгийн Засаг даргын 2018 оны А/871 дүгээр захирамжаар байгуулагдсан “Барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комисс”-ын бүрэлдэхүүнд 3 удаа ажиллаж, 4 объектийн зураг төслийн баримт бичгийг зохих зааврын дагуу цэгцлүүлж хүлээн авч, акт үйлдэв.

Санхүү, төрийн сангийн хэлтэс:

Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системд 37 төсөвт байгууллагын данс, 37 нэмэлт төсвийн данс, 25 сангийн данс нийт 99 дансны зарлагын гүйлгээг програмд шивэж төв төрийн санд дамжуулж, төлбөрийн баримтын архивын нэгж үүсгэн ажиллаж байна.

Аймгийн 2019 оны 05 сарын гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлого 11.7 тэрбум төгрөг, төлөвлөгөөтэй харьцуулахад 72 хувь байна. Төсвийн орлогыг эдийн засгийн ангиллаар нь авч үзвэл татварын орлогоор 7.1 тэрбум төгрөг төсөвт төвлөрч төлөвлөгөөтэй харьцуулахад 76.3 хувь, татварын бус орлогоор 0.9 тэрбум төгрөг төвлөрч төлөвлөгөөтэй харьцуулахад 59 хувь байна. Нийт зардал 18.3 тэрбум төгрөгийн зарлага санхүүжилт хийсэн нь төлөвлөгөөтэй харьцуулахад 75.9 хувь байна. Бүтээн байгуулалт,

хөрөнгө оруулалтын ажил арга хэмжээнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2,5 тэрбум төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 1,2 тэрбум төгрөг, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 4.5 тэрбум төгрөг, нийт 8.2 тэрбум төгрөгийг зарцуусан.

Тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтаар 10.1 тэрбум төгрөгийн санхүүжилтыг бүрэн авсан. Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт төлөвлөгөөнөөс 60.6 хувиар дутуу ирсэн байна. Аймгийн 2018 оны санхүүгийн нэгдсэн тайланг сангийн яаманд нэгтгүүлж баталгаажуулсан.

Нэмэлт санхүүжилтийн эрхийг нээхдээ Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 73 тушаалыг үндэслэн 10 удаагийн хүсэлтээр 15.6 сая төгрөгийн баримтын бүрдлийг хянаж нэмэлт төсвийн зарцуулалтын эрх нээж эрх нээсэн баримтыг архивын нэгж үүсгэн ажиллаж байна.

Замын сангийн хөрөнгөөр Хүрд шанд 2,5 сая төгрөгийн тээврийн нөхөн олговрыг олгосон.

Хадгаламж зээлийн хоршоодын Говийн бүсийн уулзалт, зөвлөгөөнийг санхүүгийн зохицуулах хороонтой хамтран 05 сарын 22-23-ны өдрүүдэд Сайншанд суманд зохион байгууллаа.

Бүртгэл хөтлөлтийн улсын үзлэгийг аймгийн татварын хэлтэстэй хамтран 04 дүгээр сарын 22-ноос 05 дугаар сарын 13-ны өдөр хүртэл 86 аж ахуйн нэгж, төсөвт байгууллагуудыг хамруулан зохион байгуулсан.

5 аж ахуйн нэгжийн албан хүсэлтээр жилийн эцсийн санхүүгийн тайланд засвар хийж, 2 аж ахуйн нэгж татан буугдаж холбогдох материалыг үндэслэн E-balance системээс хасалт хийж ажиллаа.

Мэргэшсэн нягтлан бодогчийн сургалтыг МНБИ-тай хамтран 05 сарын 17-ноос 05-р сарын 27-ны өдрүүдэд зохион байгуулсан.\

Гэр бүлийн хөгжлийг дэмжих жилийн хүрээнд 05 сард нийт 34 төсөвт байгууллагуудад “Гэр бүлийн төсөв” сэдэвт мэдээллийг Монгол банк болон Арилжааны банкуудтай хамтран зохион байгуулсан.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийт 249 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.

Боловсрол шинжлэх ухааны сайдын эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтаар эрх шилжиж ирсэн 486 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.

Татварын хэлтэс:

Улс ба орон нутгийн төсөвт 2761270.2 мянган төгрөгийн татварын орлого төвлөрүүлсэн.

Тайлант хугацаанд цахим татварын мэдээллийн шинэ системийг хэрэгжүүлэн 6 төрлийн нийт 1516 татварын тайлан хүлээн авч шийдвэрлэсэн. Тайлант сард нэг цэгийн үйлчилгээний өрөөгөөр утсаар болон биечлэн 548 татварт төлөгчдөд татварын хуулийн болон Цахим татварын мэдээллийн шинэ системийн заавар зөвлөгөө сурталчилгаа хийлээ. Аймгийн Улсын бүртгэлээс шинээр үүсэн байгуулагдсан 5 хуулийн этгээд болон нэмэлт өөрчлөлт хийгдсэн 19 татвар төлөгчдийн мэдээллийг хүлээн авч, НӨАТ төлөгчөөр шинээр бүртгэгдсэн 2 татвар төлөгчийн мэдээллүүдийг баазад тухай бүр шивж оруулан шинээр үүсэж байгаа татвар төлөгчдөд татварын багц хуулиар зөвлөгөө өгч ажиллалаа. НӨАТ суутган төлөгчийн тоо -345 үүнээс пос 315 шинээр 5 татвар төлөгч пос хэвлэж нэмэгдсэн

мөн төлбөрийн баримт олгоогүй болон олгосонч илгээгээгүй төлөвтэй 6 татвар төлөгчдөд шаардлага гардуулан ажилласан.

Татварын ерөнхий газрын даргын 2019 оны “Эрсдэлд суурилсан татварын хяналт шалгалтын эхний хагас жилийн төлөвлөгөө”, Татварын хэлтсийн даргын баталсан удирдамж болон татвар төлөгчөөс хасагдах хүсэлтийн дагуу 9 татвар төлөгчийг татварын хяналт шалгалтанд хамруулсан.

Татварын орлогын төлөвлөгөөг биелүүлэх, нуугдмал орлогын эх үүсвэрийг бий болгох ажлын хүрээнд 9 байгууллагаас 3093.1 сая төгрөгийн 118 мэдээллийг цуглуулж нэгтгэн тасгуудыг мэдээллээр ханган ажиллалаа.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албанд гүйцэтгэх ажиллагаа хийгдэж байгаа 22 төлбөр төлөгчөөс 2төлбөр төлөгчийн 2,8 сая/төг-ийг бүрэн барагдуулж гүйцэтгэх хуудсыг дуусгавар болгосон.

Жил бүрийн 05 дугаар сарын 2 дахь долоо хоногт зохион байгуулагддаг “Татвар төлөгчдийн өдрүүд”-ийг 2019 оны 05 дугаар сарын 06-10 ны өдрүүдэд “Татвар хөгжлийн үндэс” уриан дор зохион байгуулан Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд Гар зураг, Зохион бичлэгийн уралдааныг зарлан 114 сурагчийн бүтээлийг хүлээн аван шалгарууллаа.

Ерөнхий боловсролын 22 сургуулийн 947 сурагчдад “Татварын тухай ойлголт” сэдвээр, МСҮТ болон АШУҮИС-ийн Дорноговь салбар сургуулийн 135 оюутан, сурагчдад Цахим төлбөрийн систем сэдвүүдээр сургалт хийлээ. Мөн ажлын байрны болон танхимын сургалтыг 60 удаа хийж 3289 татвар төлөгчийг хамруулсан. Зах худалдааны 15 төвүүдийн 337 бизнес эрхлэгчдэд гарын авлага, брошур тарааж ажиллалаа.

Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх, зохион байгуулах ажлын хэсгийн Хэлтсийн даргын 2019 оны А/41 тушаалаар байгуулан төлөвлөгөөний дагуу бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Албан тушаалаасаа өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн 1 албан хаагчийн ажлыг хүлээн авч албан тушаалаас нь чөлөөллөө.

Хялбаршуулсан журмаар зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэсэн ажиллагааны 5 сарын мэдээг гарган Аймгийн Прокурорын газарт хүргүүллээ.

Санхүүгийн хяналт, аудитын алба

Зорилтот арга хэмжээний хэрэгжилтийн явц: Албаны дарга аймгийн Засаг даргатай 2019 оны төлөөлөн гүйцэтгүүлэх, хамтран ажиллах гэрээ байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Цаг үеийн ажлын мэдээлэл:

Аймгийн Засаг даргын баталсан СХААлбаны 2019 оны төлөвлөгөө, Албаны даргын баталсан 04 тоот удирдамжийн дагуу Айраг сумын төсөвт байгууллагууд, сангуудын 2017-2018 онуудын санхүүгийн үйл ажиллагаанд албаны дарга Х.Оюунтуяа ахлан Санхүүгийн хяналт, шалгалтын улсын ахлах байцаагч, дотоод аудитор Б.Золзая, Санхүүгийн хяналт, шалгалтын улсын байцаагч, дотоод аудитор Ж.Болор-Эрдэнэ, Н.Бүрэнтэгш, дотоод аудитор Д.Отгонбаяр, Д.Отгон нар 2019 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлүүлэн хяналт, шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн У.Шинэчимэгийн 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах арга зүй”-н сургалтанд архив, бичиг хэргийн эрхлэгч, дотоод ажилтан Т.Анхчимэг хамрагдав.

Аймгийн Засаг даргаар батлуулсан СХААлбаны 2019 оны төлөвлөгөө, Албаны даргын баталсан 06 тоот удирдамжийн дагуу Орон нутгийн өмчийн 2017-2018 оны санхүү, аж ахуйн үйл

ажиллагаанд Аудитын санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч, дотоод аулитор Н.Бүрэнтэгш, 07 тоот удирдамжийн дагуу Саран хөхөө театрын 2017-2018 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд албаны дарга, Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч, дотоод аудитор Х.Оюунтуяа ахлаж, дотоод аудитор Д.Отгон нар хяналт, шалгалтыг хийж гүйцэтгэж байна. Мөн албаны даргын 2019 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 08 тоот удирдамжийн дагуу Сайншанд сумын Засаг даргын Тамгын газрын санхүү, аж ахуйн үйл ажиллагаа болон нөөц сангуудын үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч, дотоод аудитор Б.Золзаяа, Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч, дотоод аудитор Ж.Болор-эрдэнэ нар шалгалтыг эхлүүлээд байгаа бөгөөд 2019 оны 05 дугаар сарын 17-ний өдрийн 09 тоот удирдамжийн дагуу 05 дугаар сарын 20-ны өдөр Өргөн сумын төсөвт байгууллагууд болон сангуудын үйл ажиллагаанд хийж эхлүүлээд байсан хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Энэ долоо хоногт 10 албан бичиг хүлээн авч, 11 албан бичгийг төлөвлөн хүргүүлсэн байна.

Албаны даргын "А" тушаал 2, "Б" тушаал 1-ийг төлөвлөн батлан гаргасан байна.

Архив, албан хэрэг хөтөлөлтийн улсын үзлэг явагдахтай холбогдуулан Архивын Ерөнхий газраас зохион байгуулсан цахим сургалтанд Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч, дотоод аудитор Б.Золзаяа, архив, бичиг хэргийн эрхлэгч, дотоод ажилтан Т.Анхчимэг нар хамрагдлаа.

Ирэх сарын ажлын мэдээлэл: Ирэх сард Алтанширээ сумын төсөвт байгууллагууд болон сангуудын үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэхээр төлөвлөөд байна.

Статистикийн хэлтэс:

Зорилтод арга хэмжээний хэрэгжилтийн явц: Сар бүрийн хөдөө аж ахуйн мэдээ тайланг 64 багаас, аж үйлдэрийн салбарын мэдээг 60 гаруй аж ахуйн нэгж, иргэдээс цуглуулан авч, нягтлан шалгаж программд шивж дамжууллаа.

Аймгийн нийгэм, эдийн засгийн 2019 оны 04 сарын танилцуулга болон илтгэлийг бэлтгэж цахимаар хэрэглэгчдэд тархааж, мөн хэлтсийн facebook болон цахим хуудсанд байршуулсан.

Хүн ам, өрхийн тоог, багаар 2006-2009 он, хэрэглээний үнийн индекс, сараар 2019 оны 1-3 сар, малын тоо, таван төрөл, сумаар 1980-1999 он, багаар 2006-2009 он, том малын зүй бусын хорогдол, сумаар 1969-2018 он, таван төрөл, сумаар 2007-2018 оны үзүүлэлтээр динамик тоон мэдээлэл бэлтгэн хэлтсийн цахим хуудсанд байршууллаа.

Аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоодын аудитын хэлтэс нь Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн үйл ажиллагаанд явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн дагуу хэлтсийн бодлогын баримт бичгийг нягтлан шалгаж, хяналтандаа аваад байна.

Сум орон нутгийн удирдлагууд болон хэрэглэгчдийг мэдээллээр хангах үйл ажиллагааг дэмжих зорилготойгоор сумын нийгэм, эдийн засгийн танилцуулга, илтгэлийн эх загварыг бэлтгэж сумдад хүргүүлээд байна.

Хүн ам орон сууцны улсын тооллогын комиссын нарийн бичгийн дарга, ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын дарга А.Амарбал 05-р сарын 28-ны өдөр Дорноговь аймагт ажиллалаа. Хүн ам, орон сууцны 2020 оны тооллого, Байшин орон сууцны 2019

оны тооллогыг зохион байгуулж явуулах аймгийн тооллогын коимиссын гишүүдтэй уулзан, тооллогын удирдлага зохион байгуулалт, онцлог, зорилго, ач холбогдол, арга зүйн талаар мэдээлэл өгч, харилцан санал солилцов.

ҮСХ-той хамтран Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгааны үр дүнг танилцуулах, сурталчлах семинар, уулзалтыг 2019 оны 5-р сарын 28-ны өдөр Сайншанд суманд зохион байгууллаа. Семинар уулзалтанд төрийн болон төрийн бус байгууллагын 60-аад төлөөлөгчид оролцлоо.

Аймгийн ЗДТГ-ын Хяналт-Шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс Удирдлагын академийн мэргэжил дээшлүүлэх институттэй хамтран зохион байгуулсан “Бодлогын хэрэгжилтийг үнэлэх арга зүй” сэдэвт мэргэшүүлэх богино хугацааны сургалтанд 2019 оны 05-р сарын 22,23-ны өдрүүдэд хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Цэрэндорж, мөн хэлтсийн зохион байгуулагч Б. Баяржавхлан нь Улаанбаатар хотноо Баримт бичгийн стандарт, баримт бичгийг зохион бүрдүүлэх арга зүй сэдэвт 3 хоногийн сургалтанд 5-р сарын 22-24 ний өдрүүдэд хамрагдлаа.

Аймгийн Прокурорын газраас зохион байгуулсан “Зөрчил шалган шийдвэрлэх байгууллага, албан тушаалтны нэгдсэн зөвөлгөөн”-д хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Цэрэндорж оролцлоо.

ҮСХ-ноос зохион байгуулсан “Байшин, орон сууцны тооллого” сэдэвт онлайн сургалтанд хэлтсийн мэргэжилтнүүд бүрэн хамрагдлаа.

2019 оны 5-р сард Ажиллах хүчний судалгаа, Өрхийн нийгэм эдийн судалгаа, Ардчилсан засаглал судалгаанд Сайншанд, Сайхандулаан, Айраг, Алтанширээ, Мандах, Хатанбулаг, Өргөн, Эрдэнэ сумдын нийт 106 өрх хамрагдах юм. Одоогоор Сайншанд, Сайхандулаан, Айраг, Алтанширээ, Мандах, Хатанбулаг, Өргөн, Эрдэнэ сумдын 86 өрхөөс судалгааг авч, Үндэсний Статистикийн хороонд дамжуулах бэлтгэл ажил хийгдэж байна.

Орон нутгийн өмчийн газар:

Орон нутгийн өмчийн хүрээнд: Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Орон нутгийн өмчийн газрын 2019 оны хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөний дагуу “Чандмань бадрал” ОНӨХХК, “Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК”-иудад 2019 оны 05 сарын 21-ны өдрөөс 2019 оны 05 сарын 24-ний өдрийг хүртэл хяналт шалгалтыг хийсэн.

Худалдан авах ажиллагааны хүрээнд:

2019 оны аймгийн Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу зарласан дараах төсөл арга хэмжээнд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл хүргүүлсэн.

Айраг сумын соёл, спортын төвийн барилга барих ажил нарийвчилсан үнэлгээ хийж байна.

Сайншанд сумын 4-р багийн Иргэдийн хөгжлийн төвийн барилга барих ажил нарийвчилсан үнэлгээ хийж байна.

Хатанбулаг сумын Ханги боомтын тайлбайн гэрэлтүүлэг хийх ажилд нарийвчилсан үнэлгээ хийж байна.

Сайншанд сумын 2,3,6-р багийн авто зам дагуу гэрэлтүүлэг шинээр хийх ажилд нарийвчилсан үнэлгээ хийж байна.

Дорноговь Замын-Үүд сумын цэцэрлэгийн барилга барих ажилд нарийвчилсан үнэлгээ хийж байна.

Дорноговь Өргөн суманд спорт заалны барилга барих ажилд нарийвчилсан үнэлгээ хийж байна.

Цагдаагийн газрын уулзвараас Хамарын хийд явах замын төлбөр хураах цэг хүртэл автозамын гэрэлтүүлэг хийх ажилд нарийвчилсан үнэлгээ хийж байна.

Дорноговь Сайншанд суманд Кино театрын барилга барих ажлын хариу мэдэгдэл хүргүүлсэн.

Сайншанд сумын 4-р багт спортын задгай талбай бүхий “Буянт ухаа” цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлын хариу мэдэгдэл хүргүүлсэн.

Улаанбадрах суманд соёл, спортын төвийн барилга барих ажлын хариу мэдэгдэл хүргүүлсэн.

Дорноговь Алтанширээ сумын ЭМТ-ийн өргөтгөлийн барилга барих ажлын хариу мэдэгдэл хүргүүлсэн.

Газрын төлөв байдалд чанарын төлөвлөгөөт хянан баталгаа хийх ажил

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу зарласан дараах төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтыг зарласан.

1. Эрдэнэ суманд спортын талбай барих ажил
2. Дэлгэрэх сумын 0,4 квт-ын ЦДАШ-ын өргөтгөлийн ажил
3. Замын-Үүд сумын 1-р цэцэрлэгийн барилгын дотор сантехник, гадна бохир усны шугамын их засварын ажил
4. Мандах сумын цэцэрлэгийн барилга барих ажил
5. Сайншанд сумын Хуучин орон сууцны барилгуудын дээвэр, дулаалга, гадна фасадны засварын ажил

6. Сайншанд сумын ЕБ-ын 1 дүгээр сургуулийн дотуур байрны засвар
7. Шинэ хөдөө төслийн ажил
8. Замын-Үүдийн 1-р цэцэрлэгийн гадна дулаан шугам сүлжээний ажил
9. Эрдэнэ сумын спорт талбай барих ажил
10. Дэлгэрэх сумын 0.4 квт-ын ЦДАШ-ын өргөтгөлийн ажил

Гэрээ байгуулсан төсөл арга хэмжээ байна. Үүнд:

1. Алтанширээ сумын төвийн инженерийн нэгдсэн шугам сүлжээ, барилга байгууламж барих ажил
2. Аймгийн төвийн Гэр бүлийн талбайд лед дэлгэц байрлуулах ажил
3. Сайншанд сумын 2-р сургууль, Замын-Үүд сумын 2-р сургуульд турникет систем суурилуулах ажил
4. Алтанширээ сумын Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга барих ажил
5. Иххэт сумын Эрүүл мэндийн төвийн их засварын ажил
6. Сумдад бохир ус шингээх байгууламж шинээр барих зураг төсөв боловсруулах ажил
7. Сайншанд 3 дугаар цэцэрлэгийн барилгын гадна дулаан цэвэр усны шугам, сүлжээ, дээврийн засварын ажил
8. Дэлгэрэх, Эрдэнэ сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажил
9. Хөвсгөл сумын төвийн төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ, барилга байгууламжийн зураг, төсөв боловсруулах
10. Эрдэнэ сумын төвийн төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ, барилга байгууламжийн зураг, төсөв боловсруулах
11. Хатанбулаг сумын төвийн төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ, барилга байгууламжийн зураг, төсөв боловсруулах
12. Даланжаргалан сумын төвийн төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны шугам, сүлжээ, барилга байгууламжийн ажил
13. Шинэ хөдөө-Дорноговь төслийн 3-р багц
14. Сайншанд-Хамарын хийд чиглэлийн авто замаас Ханбаянзүрх чиглэлийн хатуу хучилттай авто зам /6.85 км/ барих ажил
15. Улаанбарах сумын төвлөрсөн шугам сүлжээний цэвэр усны шугамын угсралтын ажил
16. Сайншанд сумын 2-р баг шизүокагийн гудамжны 0,5 км автозамыг шинэчлэх ажил
17. Сайншанд сумын 4-р багийн 12-р цэцэрлэг, 320 хүүхдийн сургууль өрхийн эмнэлэг хүртэл автозам шинээр барих ажил
18. Айраг сумын цэцэрлэгийн барилгын их засварын ажил
19. Айраг сумын ариутгах татуургын шугам, насос станцын барилга, тоног төхөөрөмж угсрах ажил
20. Улаанбадрах сумын сургуулийн барилгын их засварын ажил
21. Сайншанд сумын 2 дугаар баг Шизүокагийн гудамжны 0.5 км автозамыг шинэчлэх ажил

Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэс:

Хууль тогтоомж, тогтоол шийдвэр болон аймгийн Эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 1 дүгээр улирлын тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн, дүгнэлт зөвлөмжийг хэлтсүүдэд хүргэсэн.

Статистикийн хэлтэс, Стандарт, хэмжил зүйн хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын үйл ажиллагаанд явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн, мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан.

Сумын ОНХС-ийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх тухай сургалтыг сумын ОНХС хариуцсан ажилтан болох Засаг даргын орлогч болон төрийн албан хаагч, иргэний төлөөллийг оролцуулан Айраг, Даланжаргалан, Иххэт, Алтанширээ сумдад 2019.05.15-2019.05.19-ний өдрүүдэд хийж, нийт 123 хүнийг сургалтад хамруулсан. Сумын ОНХС-ийн үйл ажиллагаанд цаашид анхаарах ажлууд, Дэлхийн банкнаас хөндлөнгийн хяналт хийлгэх аудитын байгууллагын шалгалтад бэлтгэх талаар дээрх сумдад зөвлөгөө өгч ажилласан.

Аймгийн ОНХС-ийн 2018 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх ажлыг гүйцэтгэж, төлөвлөлт болон тендер шалгаруулалтын материалд хяналт хийж дуусгасан.

Эхний хагас жилийн тайлан мэдээг хүлээн авах хуваарийг ЗДТГ-ын даргаар батлуулан, хэлтсүүдэд хүргүүлсэн. Мөн хэлтсийн гаднах самбарын мэдээллийг шинэчилсэн.

Монгол Улсын Ерөнхий сайдын 1 захирамж, Засгийн газраас ирсэн 8 тогтоол, аймгийн ИТХ-ын 1 тогтоолыг хяналтанд авч, удирдлагуудад танилцуулан, холбогдох мэргэжилтнүүдэд хувиан хүргүүлсэн.

Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жилийн 1 дүгээр улирлын тайланг нэгтгэн, цахимд оруулан, ЗГХЭГ-т хүргүүлж ажилласан.

Удирдлагын академийн Мэргэжил дээшлүүлэх институтээс зохион байгуулсан “Бодлогын хэрэгжилтийг үнэлэх арга зүй” 16 цагийн багц сургалтад 13 сумын ЗДТГ-ын дарга, 20 байгууллагын 33 мэргэжилтнийг хамруулан, 2 өдрийн сургалтыг зохион байгуулсан.

Архивын улсын үзлэгийн бэлтгэл ажлын хүрээнд Музей, сургалт судалгааны төв, Байгаль орчин, аялал жуулчлалын газар болон байгууллагын ажлын хэсэгт орж ажилласан.